

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

*/Хугацаа: 2017 оны 01 дүгээр сарын 01-ний  
өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*


Улаанбаатар хот  
2017 он

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1.1. Оршил

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2017 оны үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/02 дугаар тогтоолоор батлагдсан компанийн Бизнес төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/14 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2017 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус удирдлага болгон ажиллалаа.

### 1.2. Бүтэц, зохион байгуулалт



## ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1. МИД-ын үйл ажиллагаа, борлуулалт

МИД-ын 2017 оны борлуулалтад 21 аймгийн 329 сумын 24,148 малчин өрх хамрагдаж, 5 төрлийн малаа даатгасан бөгөөд даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15.3 хувийг эзэлж байна. Мөн борлуулалтын үйл ажиллагаанд Хаан банк, Төрийн банк зуучлан борлуулагчаар оролцсон.

Үндэсний статистикийн хорооноос 2016 оны жилийн эцсийн мал тооллогын тоон мэдээллийг авч холбогдох тооцоололд ашигласан ба 2016 онд 160,650 малчин өрх, 223,761 малтай өрх, 61.5 сая мал тоологдсон байна.

2017 оны МИД-ын борлуулалтын Малын шинэ үнийг тогтоохдоо өнгөрсөн оны малын тоон мэдээг Үндэсний Статистикийн хорооноос авч, тухайн тоон үзүүлэлтэд үндэслэн тус компанийн Андеррайтингийн газраас тооцоолон гаргаж, МИД-ын борлуулалтыг хийв.

МИД-ын 2017 оны борлуулалтын улиралд 9 даатгалын компанитай МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ байгуулж, 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал борлуулалт хийсэн.

#### МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах ажил:

- МИД-ын талаар болон МИД-ын нөхөн төлбөртэй холбоотой тус бүр 3 шторк /богино хэмжээний зар сурталчилгааны дүрс бичлэг/, 15 минутын нэвтрүүлгийг “Сүлд”, “Малчин” телевиз болон өөрийн компанийн цахим хуудсаар түгээсэн. Мөн Үндэсний радиогоор 4 төрлийн ярилцлага нэвтрүүлэг бэлдүүлж түгээлээ.
- Малчдад зориулан цаг тооны бичгийг “Шинэ өнгө” ХХК-иар 20.0 мянган ширхгийг хэвлүүлж даатгалын компаниудаар дамжуулан хүргүүлсэн.
- “Ард” болон “Эм Эй Ти” хэвлэлийн газраар МИД-ын талаар мэдээлэлтэй малчдад зориулсан “Даатгал” сониныг 40.0 мянган ширхгийг хэвлүүлж, зуучлагч банкнууд болон даатгалын компаниуд, Автотээврийн үндэсний төвийн орон нутгийн үйлчилгээний автобусны зорчигчдод тараасан.
- Хөдөө орон нутгаар авто тээврийн үзлэг оношилгоо явагдаж байгаатай холбогдуулж ХХААХҮЯ-тай хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд малчдад МИД-ын талаар сурталчлан таниулах, малчдыг идэвхжүүлэх зорилгоор сургалт өдөрлөгийг аймаг, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасагтай хамтран зохион байгууллаа.
- Мөн энэ үеэр тухайн сумын даатгалын компанийн болон зуучлагч банкны ажилтан нартай уулзан, гарч буй хүндрэлтэй асуудлуудын талаар ярилцан заавар зөвлөгөө өгөн, МИД-ын талаар сургалт хийсэн.
- “Мөнхийн үсэг” ХХК-иар зуучлагч Төрийн банк болон Хаан банканд МИД-ыг зуучлан даатгаж буй талаарх мэдээлэл агуулсан сурталчилгааны зурагт хуудас /постер/ тус бүр 500 /нийт 1000/ ширхэг хэвлүүлж өгсөн.
- Даатгалын компаниудад өөрсдийнх нь гаргасан төлөвлөгөө, тооцооллын дагуу тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/04 дүгээр тогтоолоор батлагдсан МИД-ын баталгааны маягтыг хэвлүүлэн тарааж өгсөн.
- МИД-ыг таниулах, сурталчлах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 330 сумын 1,600 гаруй багийн Засаг дарга нарын дунд “Малчдад ээлтэй багийн Засаг дарга” уралдааныг зарлаж, 2,000 ширхэг гарын авлага, 4,000 ширхэг уралдааныг дүгнэх тайланг хэвлүүлэн, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын ажлын чиглэл өгсөн албан бичгийн хамт хүргүүлж, багийн Засаг дарга нарт тараасан.
- “Малчдад ээлтэй багийн Засаг дарга” уралдааныг дүгнэн шалгаруулах тайланг орон нутгаас авахтай холбогдуулж холбогдох аймаг, сумдын ажилтан, мэргэжилтнүүдтэй холбогдон тайлан ирүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан ба Баян-Өлгий, Говь-

Алтай, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар зэрэг 5 аймгийн багийн Засаг дарга нар идэвхтэй оролцож тайлангаа ирүүлснийг хүлээн авч уралдааны удирдамжийн дагуу 16 багийн Засаг дарга нарыг шалгаруулж, мөнгөн шагнал олголоо.

- МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх, төлөөлөгч нарыг идэвхжүүлэх зорилгоор 2017 онд МИД-ын борлуулалт хийх эрх авсан нийт даатгалын төлөөлөгчдийн дунд “МИД-ын Манлай даатгалын төлөөлөгч” болон “Аймгийн тэргүүний даатгалын төлөөлөгч” уралдааныг зохион байгуулж, удирдамжийн дагуу “Тэнгэр даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК гэсэн 7 даатгалын компанийн 19 төлөөлөгчийг шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагнал гардуулсан.
- Орон нутгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага болон Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдтэй холбогдон Монгол Улсын Шадар сайдын албан даалгавар, ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын ажлын чиг үүргийг хүргүүлж, мэдээлэл солилцон хамтран ажиллав. Шадар сайдын өгсөн албан даалгаврын гүйцэтгэлийг орон нутгаас авч, нэгтгэн тайлагналаа. Албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласнаар 2017 оны МИД-д хамрагдалтын төлөвлөгөө 120.7 хувиар, борлуулалтын орлогын төлөвлөгөө 110.9 хувиар тус тус биелсэн байна.
- Сар бүрийн сүүлээр борлуулалтын явцын мэдээг оролцогч талуудад хүргүүлж ажилласан. Ингэснээр оролцогч талууд нь МИД-ын борлуулалтын явц ямар байгаа талаар бусад талуудын мэдээллийг авах бөгөөд энэхүү мэдээлэлдээ үндэслэн юуг анхаарахаа төлөвлөн ажиллалаа.
- МИД-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх, түүний ач тусыг малчдад сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Баянхонгор аймагт хөлсөөр ажиллах гэрээгээр 5 ажилтныг ажиллуулж, сар бүрийн ажлын тайланг хүлээн авч, дүгнэж ажиллалаа. Үүний үр дүнд Баянхонгор аймагт хамгийн өндөр буюу 3706 өрх МИД-д хамрагдсан байна.
- Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Увс, Архангай, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Булган аймгуудад МИД-ын борлуулалтын үйл ажиллагаатай танилцах, малчдад компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, оролцогч даатгагчдын салбар болон даатгалын төлөөлөгчдийн санал сонсох, тэднийг идэвхжүүлэхээр компанийн ажилтнууд борлуулалтын хугацаанд томилолтоор ажиллалаа.
- Орон нутагт ажиллах үеэр зуучлагч банк болон даатгалын компанийн төлөөлөгч нарын хооронд гарч буй үл ойлголцол, зөрчлийн талаар ярилцан, зөв ойлголтуудыг өгч, сумын удирдлага, сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтэн, малчдад МИД-ын талаар сургалт хийсэн.

МИД-ын борлуулалтыг 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосон бөгөөд нийт **24,148** малчин өрх хамрагдаж, борлуулалтын орлого **2,329,114,961.78 /хоёр тэрбум гурван зуун хорин есөн сая нэг зуун арван дөрвөн мянга есөн зуун жаран нэгэн төгрөг далан найман мөнгө/** төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5.4 мянган өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Оролцогч даатгагч, зуучлагч банкны ажилтнуудад МИД-ын сургалт, идэвхжүүлэлт:

Зуучлагч Төрийн банк болон Хаан банктай хамтран ажиллах гэрээг хоёр талын саналыг тусган, зуучлагчийн болон тус компанийн хуульчдаар хянуулан батлууллаа.

Хаан банк болон Төрийн банктай МИД-ыг зуучлан борлуулах ажлын хүрээнд "МИД-ын зуучлагчаар ажиллах журам"-ыг оролцогч талууд /9 даатгалын компани/-аас санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/07 дугаар тушаалаар батлан мөрдөн ажилласан.

МИД-ын борлуулалт эхэлж байгаатай холбогдуулан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтнууд 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 16-ны өдрүүдэд зуучлагч Төрийн банкнаас зохион байгуулдаг орон нутгийн салбаруудын нийт ажилтнуудаа чадавхжуулах сургалт дээр МИД-ын талаар болон МИД-ын программ дээр хэрхэн ажиллах талаар мэдээлэл хийлээ. Мөн харилцагч байгууллагын хүсэлтээр 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр “Практикал даатгал” ХХК-ийн ажилтнуудад МИД-ын тухай сургалтыг явууллаа.

Зуучлагч Төрийн банк болон Хаан банкны борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хариуцагч ажилтантай уулзан санал солилцсоны дагуу банкны талаас орон нутгийн салбар, ажилтнуудын дунд МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион явуулж байгаа уралдаанд тус компанийн зүгээс тодорхой хэмжээний урамшуулал олгохыг санал болгосныг хүлээн авч ярилцан Төрийн банктай тохиролцож, шийдвэрлэсэн.

МИД-ын борлуулалт 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр хааж байгаатай холбогдуулан оролцогч даатгалын компанийн МИД хариуцсан ажилтан нарт борлуулалтын хаалтыг хэрхэн хийх, мэдээллийг хэрхэн боловсруулах зэрэг заавар зөвлөгөө өгч, сургалт хийлээ.

МИД-ын 2017 оны борлуулалтад оролцогч 9 даатгалын компанитай МИД-ын үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээг байгуулж тухайн жилийн турш гэрээний хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажилласан ба эдгээр даатгалын компани **7,316** малчин өрхийг МИД-д хамруулж, **930,704,961.78 /есөн зуун гучин сая долоон зуун дөрвөн мянга есөн зуун жаран нэгэн төгрөг далан найман мөнгө/** төгрөгийн борлуулалт хийсэн.

МИД-ын борлуулалтын хугацаанд Хаан банк **6,802** малчин өрхийг МИД-д хамруулж, **641,580,000 /зургаан зуун дөчин нэгэн сая таван зуун наян мянган/** төгрөгийн, Төрийн банк **10,030** малчин өрхийг МИД-д хамруулж, **756,830,000 /долоон зуун тавин зургаан сая найман зуун гучин мянган/** төгрөгийн, нийтдээ зуучлалаар **16,832** малчин өрхийг МИД-д хамруулж, **1,398,410,000 /нэг тэрбум гурван зуун ерэн найман сая дөрвөн зуун арван мянган/** төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Програм хангамж:

МИД-ын 2017 оны програм хангамжид ашиглагдах өгөгдлийн санг үүсгэж суурь мэдээллүүдийг оруулсан. Үүнд:

- хэрэглэгчийн эрхийн мэдээлэл;
- малын үнийн мэдээлэл;
- мал тооллогын дүн;
- даатгалын төлөөлөгчдийн мэдээлэл;
- хураамжийн хувь;
- зуучлан борлуулалтын малын үнийн мэдээ;
- даатгалын компаниудын борлуулалт хийх сумын мэдээлэл;
- банкны хэрэглэгчийн эрхийн мэдээлэл;

Мөн 2017 оны зуучлан борлуулалтын програм, өгөгдөл оруулах програмуудад шаардлагатай өөрчлөлт сайжруулалтыг хийлээ. Үүнд:

- банкны програмд админ эрхийг борлуулалт удирдах, хэрэглэгч удирдах 2 тусдаа админ байхаар програмчилсан;
- хэрэглэгчийн тайланд сайжруулалт хийж илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой болгосон;
- банкны борлуулалтын төлөвийн хугацааны тоолуур шинэчилсэн;
- даатгалын компанийн програмд нэвтрэх хэсэгт шалгуур тавьсан;
- алдааны мэдээллийн шалгуур шинэчилсэн;

## 2.2. Газар тариалангийн уламжлалт даатгалын үйл ажиллагаа

Газар тариалан эрхэлдэг Сэлэнгэ, Дархан-Уул, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар зэрэг 6 аймгийн улаанбуудай тариалсан сум, аж ахуй нэгж тус бүрээр гаргасан мэдээг ХХААХҮЯ-наас болон эдгээр аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас гаргуулан авч, судалгаа хийсний үндсэн дээр үрийн тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг 2017 оноос эхлэн даатгалд хамруулж байх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

“Мандал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК-иудтай 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд 2017 оны улаанбуудайн даатгалын борлуулалтад хамтран ажиллах талаар уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үр дүнд “Ард даатгал” ХХК хамтран ажиллахаар болж тус компанийн газар тариалангийн даатгалын хэлбэр, улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх зорилгоор даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, андеррайтингийн гарын авлага, хохирол үнэлгээний журам, нөөц сан, хураамжийн тооцооллын танилцуулгыг бэлтгэн СЗХ-нд хүргүүлсэн.

Үрийн тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг даатгалд хамруулах зорилгоор холбогдох танилцуулга судалгааг хийж ХХААХҮЯ-ны Тариалангийн бодлого, зохицуулалтын газрын даргад танилцуулан, дэмжлэг авч ажиллалаа. ХХААХҮЯ-аас үр үржүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн үр үржүүлэх гэрээнд улаанбуудайгаа даатгуулсан байх талаар нэмэлт нөхцөл оруулсан.

Үрийн тариалан эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд харьяалагдах сумын мэдээлэлд үндэслэн, тухайн байгууллагын эргэлтийн талбайд нь тулгуурлан даатгалын үнэлгээ, хураамж, хохирлын харьцааг тооцоолж танилцуулга бэлтгэсэн. Мөн тус компаниудад даатгал хийх андеррайтингийн болон хохирол үнэлгээний зардлуудыг тооцооллоо. Тооцооллыг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1.

№	Аймаг, сум, аж ахуйн нэгжийн нэр	Даатгагчийн хүлээх хариуцлага		
		70%	60%	50%
1.	Сэлэнгэ, Цагааннуур, “Товхон хан” ХХК	10.38%	6.49%	3.89%
2.	Сэлэнгэ, Цагааннуур, “Баяндулаан-Уул” ХХК	11.18%	7.42%	4.69%
3.	Сэлэнгэ, Зүүнбүрэн, “Арвин хур” ХХК	11.30%	7.59%	4.90%
4.	Сэлэнгэ, Ерөө, “Их шинэстэй” ХХК	10.22%	6.58%	4.05%
5.	Сэлэнгэ, Орхонтуул, “Орхон хөнжил” ХХК	10.74%	6.94%	4.31%
6.	Дархан, Хонгор, “Дархан тооромт” ХХК	10.51%	6.84%	4.31%
7.	Дархан, Хонгор, “Газар өгөөж” ХХК	12.38%	8.48%	5.72%
8.	Төв, Жаргалант, “Алтан залаа” ХХК	11.21%	7.20%	4.49%
9.	Төв, Эрдэнэсант, “Буянт төв” ХХК	12.38%	8.48%	5.62%
10.	Булган, Хутаг-Өндөр, “Эг тариа” ХХК	10.03%	6.35%	3.78%
11.	Хэнтий, Биндэр, “Амжилт” ХХК	10.27%	6.33%	3.86%
12.	Хэнтий, Өмнөдэлгэр, “Энсада истерн” ХХК	12.38%	8.48%	5.72%
13.	Архангай, Төвшрүүлэх, “Бага хангай” ХХК	9.55%	5.99%	3.78%
	Дундаж	11.38%	7.48%	4.72%

ХХААХҮЯ, “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аас Дархан хот дахь Ургамал, газар тариалангийн хүрээлэнд зохион байгуулсан газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй “Монгол улсын үр тариа, улаанбуудай, тэжээлийн ургамлын нутагшсан элит болон сортын үр үржүүлэх тусгай зөвшөөрөл олгох” арга хэмжээнд 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр компанийн холбогдох ажилтнууд оролцлоо. Тус арга хэмжээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Андеррайтингийн газрын дарга улаанбуудайн даатгалын талаар танилцуулга хийж, даатгуулагчдын сонирхсон асуултад хариулт өгч, санал солилцсон.



Үр үржүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн улаанбуудайн үр тариалсан талбай болон бусад улаанбуудай тариалсан талбайд андеррайтингийн үзлэг шалгалт хийх, даатгах зорилгоор 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс 26-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Булган аймгийн 9 сумын 11 аж ахуй нэгжийн нийт 1047 га талбайн үрийн соёололт, бутлалтын байдалтай танилцаж, га талбай дахь тарьсан үрд хэмжилт хийн ажиллах үеэр “Ард даатгал” ХХК улаанбуудайн даатгалын гэрээг “Товхон хан” ХХК, “Их шинэстэй” ХХК, “Орхон хөнжил” ХХК, “Дархан тооромт” ХХК, “Газар өгөөж” ХХК, “Алтан залаа” ХХК, “Буянт төв” ХХК, “Эг тариа” ХХК, “Өгөөж мандал” ХХК зэрэг 9 аж ахуйн нэгжтэй байгууллаа.

Тайлант онд улаанбуудайн даатгалаас нийт **46,327,699.30 /дөчин зургаан сая гурван зуун хорин долоон мянга зургаан ерэн есөн төгрөг гучин мөнгө/** төгрөгийн хураамжийн орлого оруулсан.

Даатгалын гэрээний хугацаанд 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 04-ний өдрүүдэд гангийн эрсдэлийн дуудлагын дагуу Төв аймгийн Жаргалант сумын “Алтан залаа” ХХК, Эрдэнэсант сумын “Буянт төв” ХХК, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Эг тариа” ХХК, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Өгөөж мандал уул” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдэд “Ард даатгал” ХХК-ийн газар тариалан хариуцсан мэргэжилтэн, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн агрономч, андеррайтер, Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын агрономичтой хамтран талбайн үзлэг шалгалтыг хийлээ. Үзлэг шалгалтаар тус сумдад халуун, хуурай, хур тунадас багатай байсны улмаас зарим даатгуулсан талбайд ургац авахгүй болсныг тодорхойлж, тухайн сумдын Цаг уурын өртөөнөөс сумын агаар болон хөрсний температур, хур тунадасны хэмжээг тусгасан цаг агаарын тодорхойлолтыг авч хяналт шалгалтын тайланг бэлтгэсэн.

Улаанбуудайн урьдчилсан ургац тогтоолт болон бодит ургац тогтоолтыг тогтоохоор 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 22-ны өдрүүдэд “Ард даатгал” ХХК-ийн газар тариалангийн даатгалын зөвлөх, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Дэд захирал, Андеррайтингийн газрын дарга, андеррайтер, агрономч, нөхөн төлбөрийн менежер, дотоод хяналтын ажилтан нарын бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Хушаат, Орхонтуул, Ерөө, Цагааннуур, Булган аймгийн Хутаг-Өндөр, Төв аймгийн Жаргалант, Эрдэнэсант сумын нийт 9 аж ахуйн нэгжийн даатгасан талбай дээр очиж үзлэг хийсэн. Үзлэгээр талбайд 50-100 метрийн гүнд санамсаргүй байдлаар орж 20 га тутамд тооллого хийж, 1 метр квадрат талбайн тариан түрүүг тасдан авч, жигнэж, жигнэсэн түрүүгээ гар аргаар цайруулан багажаар чийгийн хэмжээг тооцоолж, чийгийн хэмжээнээс хохирлыг хасаж, хохирол үнэлгээний зааварт тусгасны дагуу урьдчилсан ургац тогтоолтыг хийв.

Урьдчилсан ургац тогтоолтын үр дүнд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Өгөөж мандал уул” ХХК, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Эг тариа” ХХК, Төв аймгийн Жаргалант сумын “Алтанзалаа” ХХК-ийн даатгуулсан талбайнууд нийтээрээ гангийн эрсдэлд өртсөн болох нь тогтоогдож дээрх 4 аж ахуйн нэгжид нөхөн төлбөр олгох урьдчилсан дүн мэдээг гаргасан.

### **2.3. Давхар даатгалын хураамжийн орлого**

#### Аaktuар тооцоолол, судалгаа:

Оролцогч даатгалын компаниудын 2017 оны борлуулалтын төлөвлөгөөг авч нэгтгэн давхар даатгалын хураамжийн тооцооллыг гаргасан ба 2017 онд МИД-д оролцогч даатгалын компаниудтай гэрээ байгуулан баталгаажуулсан.

“Давхар даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон СЗХ-ны хяналт, зааврын дагуу төлбөрийн чадварын харьцааг тооцооллоо.

2017 оны 4 дүгээр улирлын байдлаар төлбөрийн чадварын зохистой харьцаа 158.2 хувь байгаа нь тус журмын 2.4-д “Давхар даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

МИД-ын тухай хуулийн 7.3 заалтын дагуу 3 жил тутамд босго үзүүлэлтийг шинэчлэх ба сумын малын хорогдол, даатгуулагчийн тоо, хураамжийн орлогын хэмжээ, нөхөн төлбөр олголт гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, Хохирол хасалтын харьцаа *Loss elimination ratio*-г ашигласан. Энэхүү харьцаа нь даатгалын хасалт болон хязгаарлалтыг тавьснаар даатгалын компанийн хариуцах хохирлын хэмжээ хэчнээн хувиар буурч байгааг илэрхийлдэг харьцаа юм. Тооцооллын үр дүнд МИД-ын босго үзүүлэлтийг өөрчлөхгүй байхыг зөвлөсөн.


МИД, НЭУБД, хөрөнгийн даатгал, эрчимжүүлсэн малын даатгалын бүтээгдэхүүнүүдийн хувьд даатгалын нийт үнэлгээ, хураамж, нөөц сан, давхар даатгалын зардлыг тооцоолж, хохирлын харьцаанд үндэслэн нөөц сангийн төсөөлөл тооцооллыг хийв.  
/Хүснэгт 2/

Хүснэгт 2. Нөөц сангийн төсөөлөл

№	Даатгалын бүтээгдэхүүн	Хохирлын харьцаа
1	МИД	32%
2	НЭУБД	29%
3	Хөрөнгө	7%
4	Эрчимжүүлсэн мал	10%

Мөн хөрөнгө, ачаа, барилга угсралт, хариуцлагын даатгалын давхар даатгалд төлсөн хураамжийн төлбөрийг сүүлийн 8 жилийн мэдээн дээр үндэслэн түүхэн хохирлын харьцаанд тулгуурлан давхар даатгагчаар төлүүлэх нөхөн төлбөрийн хэмжээнд таамаглал хийсэн.  
/График 1/

График 1.



СЗХ-ны “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан 4 төрлийн нөөц сангийн тооцооллыг дээрх 4 бүтээгдэхүүний хувьд урьдчилсан байдлаар таамаглаж, МИД болон НЭУБД-ын нөөц сангуудын дүнг мөн нэмж танилцуулсан танилцуулга бэлтгэлээ.

СЗХ-ны “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын дагуу 2017 оны 3 дугаар улирлын байдлаар МИД-ын болон нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгал /НЭУБД/-ын нөөц сангийн тооцоолол болон үр дүнг танилцуулсан актуарын тайланг бэлтгэж СЗХ-нд хүргүүлсэн. /Хүснэгт 3/

Хүснэгт 3. МИД-ын нөөц сангийн тооцооллоор

№	Нөөц	Дүн (төгрөгөөр)
---	------	-----------------



1	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	460,217,295.80
2	Хамтын эрсдэлийн сан	1,048,101,733.26
3	Хамтын эрсдэлийн сангийн нөөц	114,027,694.59
4	Дунд түвшний эрсдэлийн нөөц сан	2,456,083,052.70
5	Дээд түвшний эрсдэлийн нөөц сан	806,763,049.94

Үр тариа, газар тариалангийн даатгал хийх зөвшөөрөл авахад шаардагдах актуар тооцооллыг хийж, тооцооллын аргачлал болон үр дүнг агуулсан тайлан болон холбогдох бичиг баримтыг бэлтгэн СЗХ-нд хүргүүлсэн. Тайланд үрийн тусгай зөвшөөрөлтэй Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Товхон хан” ХХК, Ерөө сумын “Их шинэстэй” ХХК, Орхонтуул сумын “Орхон хөгжил” ХХК, Хушаат сумын “Өгөөж мандал” ХХК, Дархан-Уул аймгийн Орхон сумын “Дархан тооромт” ХХК, “Газар өгөөж” ХХК, Төв аймгийн Жаргалант сумын “Алтан залаа” ХХК, Эрдэнэсант сумын “Буянт төв” ХХК, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Эг тариа” ХХК, Хэнтий аймгийн Биндэр сумын “Амжилт” ХХК, Өмнөдэлгэр сумын “Энсада истерн” ХХК, Архангай аймгийн Төвшрүүлэх сумын “Бага хангай” ХХК гэсэн 13 аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулсан.

Нийт 11 сумын ургацын дүн болон цаг уурын үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг судлах зорилгоор Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн мэдээллүүдийг эмхэтгэн тооцоолол хийхэд бэлтгэн, хамаарлыг нь шалгахад 75 хувьтай байсан.

Үрийн тариалан эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд аж ахуйн нэгжийн түүхэн мэдээлэл болон харьяа сумын мэдээлэлд үндэслэн, тухайн байгууллагын эргэлтийн талбайд нь тулгуурлан даатгалын үнэлгээ, хураамж, гарч болзошгүй нөхөн төлбөрүүдийг тооцоолж, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Товхон хан” ХХК, Ерөө сумын “Их шинэстэй” ХХК, Орхонтуул сумын “Орхон хөгжил” ХХК, Хушаат сумын “Өгөөж мандал” ХХК, Дархан-Уул аймгийн Орхон сумын “Дархан тооромт” ХХК, “Газар өгөөж” ХХК, Төв аймгийн Жаргалант сумын “Алтан залаа” ХХК, Эрдэнэсант сумын “Буянт төв” ХХК, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Эг тариа” ХХК гэсэн 9 аж ахуйн нэгж тус бүрд танилцуулга хийв.

Сэлэнгэ аймгийн Хушаат, Дорнод аймгийн Баянтүмэн, Төв аймгийн Баянцогт сумуудад улаанбуудайн тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн даатгалын үнэлгээ, хураамж, хохирлын харьцааг аж ахуйн нэгжийн боломжит мэдээлэл болон тухайн сумдын мэдээнд үндэслэн тус тус тооцооллоо. Хохирлын харьцаа нь аж ахуйн нэгжүүдийн түвшинд 28 хувь, сумын түвшинд 9 хувь байна. Хохирлын харьцааг аж ахуйн нэгжийн болон сумын дунджаар 92 хувиар үнэлэн нөөц санг байгуулахаар тооцоолсон.

#### Давхар даатгалын хураамжийн орлого

Давхар даатгалын хураамжийн орлого 2017 оны борлуулалтын улиралд МИД-ын эрсдэлийн **дунд түвшинд 770,400,381.62** /долоон зуун далан сая дөрвөн зуун мянга гурван зуун наян нэгэн төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөг, МИД-ын эрсдэлийн **дээд түвшинд 487,800,000.00** /дөрвөн наян долоон сая найман зуун мянган/ төгрөг, **Нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгалд 11,720,907.92** /арван нэгэн сая долоон зуун хорин мянга есөн зуун долоон төгрөг ерэн хоёр мөнгө/, **нийт 1,269,921,289.54** /нэг тэрбум хоёр зуун жаран есөн сая есөн зуун хорин нэгэн мянга хоёр зуун наян есөн төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгийн орлого орсон байна.

#### **2.4. Олон улсын давхар даатгалын байгууллагын хамтын ажиллагаа**

##### МИД-ын олон улсын давхар даатгалын гэрээ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/02 дугаар тогтоолоор батлагдсан “2017 оны бизнес төлөвлөгөө”-нд үндэслэн МИД-ын дунд болон дээд түвшний тодорхой хэмжээний эрсдэлийг олон улсын давхар даатгалд

хамруулах тооцооллыг боловсруулан үнийн санал авах албан тоотыг түвшин тус бүрээр боловсруулж олон улсын даатгагч нарт хүргүүлсэн. Үүнд:

1. *Эрсдэлийн дээд түвшин:* МИД-ын дээд түвшний давхар даатгалд хамруулах эрсдэлийн хэмжээг төлөвлөж буй нийт сонгосон үнэлгээ /47.4 тэрбум/-ний 0.3 хувь давсан 2.9 хувь болон 0.2 хувь давсан 2.9 хувиар тогтоон, хамтран ажилладаг Швейцарын давхар даатгалын групп /“Swiss Re”/, Ханновер Ре давхар даатгалын групп /“Hannover Re”/, Эйзиа Либерти Ази тивийн эрх чөлөө компани /“Asia Liberty”/ болон Сомпо Канопиус компани /“Sompo Canopus”/ зэрэг давхар даатгагч нарт үнийн санал ирүүлэх хүсэлтийг;
2. *Эрсдэлийн дунд түвшин:* МИД-ын дунд түвшний давхар даатгалд хамруулах эрсдэлийн хэмжээг төлөвлөж буй нийт хураамж /850,000 ам.доллар/-ийн 60 хувь давсан 130 хувь болон 65 хувь давсан 125 хувиар тогтоон, хамтран ажилладаг СКОР групп /“SCOR”/, Ханновер Ре давхар даатгалын групп /“Hannover Re”/, Эйзиа Либерти Ази тивийн эрх чөлөө компани /“Asia Liberty”/ болон Катар Ре давхар даатгалын компани /“Qatar Re”/ зэрэг давхар даатгагч нарт үнийн санал ирүүлэх хүсэлтийг тус тус хүргүүлсэн.

Дээрх Олон улсын давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналтай танилцаж, хамгийн бага үнийн санал /нийт хураамжийн 13 хувь/ ирүүлсэн СКОР /“SCOR”/ олон улсын давхар даатгалын компанитай нийт хураамжийн 65 хувь давсан 125 хувийн эрсдэлийг давхар даатгах хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

#### Газар тариалангийн даатгалын олон улсын давхар даатгалын гэрээ

Компанийн зүгээс ХХААХҮЯ-тай хамтран 2017 оны бизнес төлөвлөгөөний дагуу газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг “Ард Даатгал” ХХК-иар дамжуулан 2017 онд үрийн тариа үржүүлэх зорилгоор сонгогдсон “Товхон хан” ХХК, “Их шинэстэй” ХХК, “Орхон хөгжил” ХХК, “Дархан тооромт” ХХК, “Газар өгөөж” ХХК, “Алтан залаа” ХХК, “Буянт төв” ХХК, “Эг тариа” ХХК, “Өгөөж мандал” ХХК зэрэг 9 аж ахуй нэгжийг НЭУБД-д хамруулсан. Энэхүү бүтээгдэхүүний нийт даатгалын хариуцлагын 97 хувийг давхар даатгах зорилгоор “Хөдөө аж ахуйн хувь оролцооны давхар даатгалын гэрээ”-г “Ард даатгал” ХХК-тай байгууллаа. Мөн даатгалын хариуцлагын 80 хувийг СКОР /“SCOR”/ давхар олон улсын даатгалын компанид шилжүүлэх давхар даатгалын гэрээг байгуулсан.

#### Олон улсын давхар даатгалын бусад байгууллагатай хамтран ажиллах талаар

ХБНГУ болон Швейцар Улсад 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 3 дугаар сарын 01-ний өдрүүдэд Андеррайтингийн газрын дарга, Бизнес хөгжил, төслийн газрын дарга нар албан томилолтоор ажиллав.

Энэ үеэр газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах ажлын хүрээнд олон улсын давхар даатгагчидтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, давхар даатгалын гэрээ байгуулахад дэмжлэг тусалцаа авах, туршлага судлах, дадлага эзэмших, компани хоорондын харилцааг хөгжүүлэн түншлэлийн шинэ шатанд авчрах зорилгоор Швейцар Улсын Цюрих хотод байрлах Цельсиус Про /“Celsius Pro”/ цаг агаарын даатгалын зуучлагч компани болон СКОР /“SCOR”/, Катар Ре /“Qatar Re”/ олон улсын давхар даатгалын компаниуд, ХБНГУ-д байрлах Ханновер Ре /“Hannover Re”/ олон улсын давхар даатгалын компани, PWC-Пи Даблю Си /“Price Waterhouse Coopers”/ олон улсын санхүүгийн байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж цаашид хэрхэн хамтран ажиллаж болох боломжуудын талаар санал солилцон, туршлага судалсан.

Олон улсын даатгалын компаниудын мэдээллийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг АКСКО /“АХСО”/ даатгалын мэдээллийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани, Беларус Улсын үндэсний давхар даатгалын Беларусын үндэсний давхар даатгалын /“Belarus Re”/ компани, ОХУ-ын үндэсний давхар даатгалын /“РНПК”/ компани, Украин Улсын давхар даатгалын

“Ингосстрах” компани зэрэг олон улсын давхар даатгалын компаниудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчныг судалж, хамтран ажиллах талаар судалгаа боловсруулж, туршлага судлах зорилгоор цахим шуудангаар харилцаа тогтоов.

Бүгд Найрамдах Филиппин Улсад суугаа Монгол Улсын өргөмжит консултай холбоо тогтоож, түүгээр дамжуулан хамтын ажиллагаа тогтоох тухай саналаа Филиппин Улсын /“PhilNa Re”/ үндэсний давхар даатгалын корпорацид хүргүүлж, хамтын ажиллагаа тогтоох хүсэлтийг тухайн корпорациас хүлээн авлаа.

Тайландын Вант Улсын /“Thai Re”/ үндэсний давхар даатгалын байгууллага/үндэсний давхар даатгалын корпорацитай хамтын ажиллагаа тогтоож, туршлага судлах зорилгоор хамтын дэмжлэг хүсэх тухай албан бичгийг Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа элчин сайдын яаманд хүргүүлсэн.

## ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

### 3.1. Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн

#### Тариалангийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа

Сангийн сайд 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр тус компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцахдаа тариалангийн даатгалыг хэрэгжүүлэх талаар холбогдох судалгаа хийхийг үүрэг болгосон. Үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох хууль, журамтай танилцаж, тариалангийн салбарт төрөөс үзүүлж буй дэмжлэгийг санхүүгийн арга механизмаар хэрхэн үр ашигтай хэрэгжүүлэх, түүний бүтэц, зохион байгуулалтыг тусгасан судалгааг боловсруулж Сангийн сайдад хүргүүлэв.

ХХААХҮЯ-ны сайдын А-42 дугаар тушаалаар байгуулагдсан Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн 2 дугаар хуралдааныг 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК зохион байгууллаа. Тус хуралдаанаар тариалангийн даатгалын хуулийн зарчим, санхүүжилтийн талаарх санал боловсруулж хэлэлцүүлэг хийв. Хэлэлцүүлгээр Хуулийн ажлын хэсгийн гишүүдэд хуулийн төсөл боловсруулахтай холбоотой тандах судалгааны холбогдох тооцоолол, танилцуулгыг бэлтгэн хүргүүлсэн бөгөөд энэхүү судалгааг ХХААХҮЯ нэгтгэн хийлээ.

ХХААХҮЯ-наас зохион байгуулсан “Тариаланчдын улсын зөвлөгөөн” 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр болж, 21 аймаг, нийслэлийн 500 гаруй тариаланчид оролцож, 2017 оны тариалалтын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, технологийн талаар санал солилцлоо. Мөн зөвлөгөөнд Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд технологи, үр сортын сонголт, хөрс боловсруулалт, таримлын сэлгээний талаарх зөвлөмж өгч, Цаг уур, орчны шинжилгээний газраас 2017 оны зуны цаг агаарын мэдээ болох дулаан, хур тунадас, салхины мэдээллийг тариалангийн бүс нутгаар урьдчилсан байдлаар танилцуулсан.

Тус зөвлөгөөнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал “Тариалангийн даатгалын хэрэгжилт, цаашдын чиг хандлага, Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл”-ийн талаар танилцуулга хийн түүнтэй холбоотойгоор 270 гаруй тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс тариалангийн даатгалын хуулийн төсөлд асуулгаар санал, судалгааг авч судалгааны үр дүнг ХХААХҮЯ руу явуулсан. Судалгаа өгсөн тариаланчдын 82 хувь нь тариалангийн даатгал шаардлагатай гэж үзсэн бөгөөд 16 хувь нь мэдэхгүй, 2 хувь шаардлагагүй хэмээн үзсэн байна.

Тариалангийн даатгалын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор зөвлөгөө үзүүлэх Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуйн төсөл”-тэй дараах ажлуудыг хамтран хийлээ.

1. Төслийн олон улсын зөвлөх Себастиан Малер /"Гөфауэф-Ферзихэрунгс-Маклер" ХХК/ Тариалангийн даатгалын хуулийн төсөлд өөрийн саналаа өгсөн бөгөөд тус саналыг "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК нэгтгэн боловсруулж СКОР /"SCOR"/ компани руу явуулсан. 2017 оны 02 дугаар сарын 15, 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт зөвлөхийн саналыг танилцуулсан.
2. Төслийн хүрээнд тариалангийн даатгалын хуулийн төсөлд мэргэжлийн зөвлөгөө өгөх, олон улсын тариалангийн даатгалын хуулийн туршлагыг хуваалцах зорилгоор БНКаЗУ-ын иргэн, олон улсын даатгалын зөвлөх доктор Ихтиёр Бобоёонов 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсад айлчилж, "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн төлөөлөл, "Ард даатгал" ХХК-ийн дэд захирал болон тариаланчдын төлөөлөлтэй уулзаж, тариалангийн даатгалын Монголын Улсын болон олон улсын туршлагын талаар санал бодлоо солилцлоо. Мөн 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Тариалангийн даатгалын хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгтэй олон улсын даатгалын зөвлөх доктор Ихтиёр Бобоёонов ОХУ, БНКаЗУ, Узбекистан улсуудад хэрэгжүүлж буй тариалангийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулга тавьж, зөвлөгөө өгсөн.
3. Төслийн хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 11-ний өдрүүдэд Ханновер Ре /"Hannover Re"/ давхар даатгалын компанийн газар тариалан хариуцсан андеррайтер доктор Лайф Хаймфарт Монгол Улсад хүрэлцэн ирж, "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК, Сангийн яам, ХХААХҮЯ, СЗХ-ны холбогдох удирдлага, мэргэжилтэн, даатгалын компани болон тариалан эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзаж газар тариалангийн олон улсын туршлага, индексжүүлсэн даатгалын талаар танилцуулга хийж, харилцан санал солилцсон бөгөөд тариалангийн даатгалтай холбоотой асуулга судалгаа хийсэн. Доктор Лайф Хаймфарт оролцогч бүх талуудад уламжлалт даатгал зардал өндөртэй байдаг тул цаашид тариалангийн даатгалын хэрэгцээ шаардлагатай байгаа, индексжүүлсэн даатгалыг туршиж судлах, холбогдох санхүүжилтийг тодорхой болгох зэрэг зөвлөмжүүдийг өглөө. Индексжүүлсэн даатгалын цаг уурын хүчин зүйл ургацад хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа, тооцооллыг хийхтэй холбогдуулж Сэлэнгэ, Булган, Хэнтий аймгийн сумдын цаг уурын станцаас авсан цаг уурын мэдээллийг явуулсан бөгөөд үр дүнд цаг уур станцын мэдээлэл нь ургацын мэдээтэй хамааралгүй болохыг тогтоосон.
4. Төслийн хүрээнд Тариалангийн даатгалын техник эдийн засгийн үндэслэл, тооцоолол хийх олон улсын зөвлөх Себастиан Малерыг гэрээлэн авч ажиллуулах болсны дагуу зөвлөхийн ажлын удирдамжийг боловсруулж, төсөлд хүргүүлсэн. 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр төслийн олон улсын зөвлөх Себастиан Малертай цахимаар холбогдож, ажлын удирдамжийн талаар харилцан санал солилцож, хийх ажлууд дээрээ тогтлоо. Зөвлөхийн хийх ажлын хүрээнд холбогдох тариалангийн болон цаг уурын талаар мэдээлэл бэлтгэн явууллаа.

Тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөл 2019 онд батлагдахаар төлөвлөгдөж байна.

**Газар тариалангийн индексжүүлсэн даатгал хэрэгжилтийн хүрээнд:**

Тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, холбогдох тооцоолол судалгааг хийх, зах зээлд турших зорилгоор олон улсын давхар даатгалын СКОР /"SCOR"/ компани, Цельсиус Про /"Celsius Pro"/ компани буюу цаг уурын мэдээллийн сан /платформ/ ашиглаж даатгалын үйл ажиллагаа явуулдаг компаниас хэрэгжүүлж буй даатгалын тухай танилцуулга болон үнийн саналыг авч, цахим хурал хийж, бүтээгдэхүүний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Үүний үр дүнд олон улсын давхар даатгалын СКОР

/"SCOR"/ компанийн загварчлал нь илүү үр дүнтэй байсан тул тус компанитай индексжүүлсэн даатгалыг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгууллаа.

Гэрээний хүрээнд индексжүүлсэн даатгалын загварчлал боловсруулах зорилгоор АНУ-ын хөдөө аж ахуйн салбарын мэдээлэл технологийн үйлчилгээ болон бүтээгдэхүүн хөгжүүлдэг дэлхийд тэргүүлэгч ЗЭДКС /"ZEDX"/ компанид туршилтаар хэрэгжүүлэх сумдын 2000-2016 он хүртэлх хур тунадас, агаарын температур, хөрсний температур, чийг, нарны гийгүүлэлтийн мэдээлэл, 2017 оны ургацын мэдээлэл, цаг уурын мэдээлэл болон 2017 онд НЭУБД-ын бүтээгдэхүүнд даатгуулсан 9 аж ахуйн нэгжийн талбай, ургац, хөрсний мэдээллийг боловсруулан хүргүүллээ. Мөн ургамлын ургацын физиологийн хөгжилд шаардлагатай хөрс болон цаг уурын нөхцөл байдалд суурилсан агрономийн загвар байдаггүй тул ХХААХҮЯ-ны зөвлөснөөр Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнд хүсэлт хүргүүллээ.

Олон улсын давхар даатгалын СКОР /"SCOR"/ компаниас ирүүлсэн тариалангийн индексжүүлсэн даатгалыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх танилцуулгатай танилцаж, тус компани болон АНУ-ын ЗЭДКС /"ZEDX"/ компанитай хэд хэдэн удаагийн цахим /онлайн/ хурал зохион байгуулж, даатгалын бүтээгдэхүүний зарчим, шаардлагатай өгөгдөл /дата/ мэдээлэл, зардлын талаар хэлэлцэж, манай компаниас газар тариалангийн талбай, тариалалт, ургацын талаарх мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн.

Франц Улсын Парис хотод 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан "СКОР /"SCOR"/ Хөдөө аж ахуйн өдөр-Технологийн шийдлийг ашиглан хөдөө аж ахуйн даатгалыг хөгжүүлэх, цаашдын хэтийн төлөв" сэдэвт семинарт Андеррайтингийн газрын дарга, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, газар тариалангийн андеррайтер нар оролцож, СКОР /"SCOR"/ давхар даатгалын компанийн тариалангийн индексжүүлсэн даатгалын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, технологийн дэвшил буюу хиймэл дагуул ашиглан ургацыг үнэлэх, хохирол үнэлгээ тооцох талаар ойлголт авч, бусад улсын туршлагын талаар мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааныхаа талаар харилцан санал солилцлоо.

Цаг уур, орчны шинжилгээний газраас Архангай, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дорнод аймгийн 15 сумын цаг уурын станцаас гардаг хур тунадас, агаарын температур, хөрсний чийг, салхины мэдээллийг 2000-2016 он хүртэл нийт 365 өдрөөр хүлээн авч, уг мэдээллийг ашиглан индексжүүлсэн даатгалын хүрээнд цаг уурын мэдээлэл ургацад хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгаа хийж СКОР /"SCOR"/ болон Ханновер Ре /"Hannover Re"/ давхар даатгалын компаниудад илгээн судлуулах ажил хийгдэж байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгууллаа. Тус гэрээ нь тариалангийн зориулалттай ашиглаж байгаа тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн газрын байршил, газар зохион байгуулалт, кадастрын зурагтай танилцаж судлах, тус мэдээллийг ашиглан тариалангийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, талууд шаардлагатай мэдээлэл, судалгааг харилцан солилцож, туслалцаа үзүүлэх зорилготой юм.

### **3.2. Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн**

Монгол Улсын Засгийн газраас 2003 оны 160 дугаар тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжүүлсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулахад зорилгоор "Эрчимжүүлсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийг баталсан билээ.



Мал аж ахуйн салбар нь байгаль, цаг уурын болоод хүний хүчин зүйлсээс хамааран эрсдэл өндөртэй салбар тул эрсдэлээс хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын тогтолцоог нэвтрүүлснээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, эрчимжүүлэх, нөөц ашиглалтыг сайжруулах, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, ДНБ-ний үйлдвэрлэлд мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Эрчимжүүлсэн мал ахуйн салбарын даатгалын бүтээгдэхүүний олон улсын туршлагыг судалсан. ОХУ-д эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалыг хэрхэн хийдэг талаар даатгалын компанийн журмыг судалж, танилцуулга бэлтгэсэн. Мөн ОХУ-ын Хөдөө аж ахуйн даатгалын төлөвлөгөө, газар тариалан болон мал амьтдын даатгалын статистик мэдээллийг боловсрууллаа. Судалгаанаас дүгнэхэд манай орны хувьд эрчимжүүлсэн мал аж ахуйн байр, тэжээлийн тухай тогтсон стандарт байдаггүй нь даатгалын хураамж тооцоход дутагдалтай байдаг байна.

Их Британи Улсын “Willis Towars Watson” /Виллис Товарс Ватсон/ брокер компанийн эрчимжүүлсэн мал аж ахуйтай холбоотой асуулга судалгааг бэлтгэв.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал хийхтэй холбоотой АНУ болон БНХАУ-ын давхар даатгалын үйл ажиллагааны журам болон даатгалын компани дахь төрийн дэмжлэгийн талаар судалгаа хийсэн.

Эдгээр судалгааны үр дүнд мал амьтдын даатгалын объект, даатгалын тохиолдлууд, тэдгээрийн ангилал, даатгалд хамаарахгүй ямар нөхцөлүүдийг оруулдаггүй талаар танилцуулга бэлтгэсэн.

Монгол Улсад эрчимжүүлсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын аж ахуй нэгжүүдийн судалгааг гаргасан. Эрчимжүүлсэн мал аж ахуйгаас онцгойлон Монгол Улсад 2007 оноос хойш импортлогдсон малыг /үхэр, хонь/ даатгалд хамруулах зорилгоор, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон аймаг, сумдын мал аж ахуйн мэргэжилтнүүдтэй холбогдон даатгалын талаарх мэдээлэл солилцон ажилласан. Энэ хугацаанд нийт 16 аж ахуйн нэгж 7 үүлдрийн 2,119 үхэр, 5 аж ахуйн нэгж 4 үүлдрийн 282 бог мал импортолсон байна.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн 2016 оны жилийн эцсийн мэдээ мэдээллийг нэгтгэж гаргасан ба манай улсад эрчимжүүлсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 2004 аж ахуйн нэгж байна.

“Макс Агро” ХХК-ийн Холстейн /“Holstein”/ үүлдрийн бух, үнээ, бяруу, тугал зэрэг нийт 460 үхрийг давхар даатгах зорилготой андеррайтингийн хурлыг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, танилцуулга бэлтгэн тайлагнасан. Уг хуралд “Тэнгэр даатгал” ХХК хураамжийн хувийг 1.5 хувь байхаар гэрээ хийсэн нь олон улсын дундаж хураамжийн хувь болох 4 хувиас бага юм. Гэрээнд тусгагдсан зарим эрсдэлийг хасах, эсвэл хураамжийн хувийг нэмсэн тохиолдолд давхар даатгах зэрэг нөхцөл тавьсан тул “Тэнгэр даатгал” ХХК-тай байгуулсан гэрээгээ цуцалсан.

“Номин даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иас ирүүлсэн үнийн санал эрчимжүүлсэн мал аж ахуйг давхар даатгах ба 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр саналаа хүргүүлсэн. “Бодь даатгал” ХХК “Макс Агро” ХХК-ийн “Holstein” /Холстейн/ үүлдрийн сүүний чиглэлийн үхрийг даатгах үнийн санал, гэрээний төслийг бэлтгэн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн.

ХААИС-ийн Мал аж ахуйн сургуулийн захирал, багш, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, эрчимжүүлсэн мал аж ахуйтай аж ахуйн нэгжүүдийг давхар даатгалд



даатгахад тохиолдож болох түгээмэл эрсдэлүүд болон фермийн барилга байгууламжийн стандарт, агааржуулалтын горим зэрэг олон асуудлаар ярилцаж санал солилцон цаашид хамтран ажиллахаар болсон.

### **3.3. Тоног төхөөрөмжийн даатгалын бүтээгдэхүүн**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 212 дугаар тогтоолоор Үндэсний хэмжээнд зохион байгуулагдах “Атрын-III аян”-ны “Газар тариалангийн техникийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн зориулалттай техникийг худалдан авахад зориулж, ОХУ-ын “Эксим” банкнаас 3-5 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр 10.0 сая ам.долларын зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

ХХААХҮЯ-ны “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аас газар тариалангийн техникүүдийг шинэчлэх ажлын хүрээнд хийгдэж буй ОХУ-аас импортолж ирсэн техникүүдийг давхар даатгах зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм лизинг” ХХК-тай 2017 оны 8 дугаар сарын 03-ны өдөр уулзалт зохион байгуулж, зээлд хамрагдан борлуулагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг авч боловсрууллаа. Уг жагсаалтад комбайн, трактор, будаа цэвэрлэгч, будаа сортлогч, сийрүүлүүр, үрлүүр зэрэг тариалан эрхлэгчдэд ургац хураахад зайлшгүй шаардагдах нийт 543 нэр төрлийн тоног төхөөрөмж орсон.

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн тоног төхөөрөмж даатгуулах хүсэлтэд үнийн санал өгч, найман арилжааны даатгалын компанитай өрсөлдсөнөөс “Хөдөө аж ахуйн давхар даатгал” компани сонгогдсон бөгөөд анхлан даатгагч компаниар тариалангийн салбарын туршлага, орон нутгийн салбаруудын тоо зэргийг харгалзан үзэж, “Ард даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК-ийг сонгон давхар даатгалын гэрээ байгуулав. “Ди Би Эм лизинг” ХХК, “Тариалан эрхлэгчдийг дэмжих сан”, анхлан даатгагч компаниудын төлөөлөлтэй уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааны гэрээ байгуулан тариаланчдыг даатган ажиллаж байна.

Одоогоор тоног төхөөрөмж түрээслэх зөвшөөрөл авсан 123 аж ахуйн нэгж, иргэн байгаа бөгөөд түрээслэн авсан тоног төхөөрөмжийн үнэлгээ 5.0 сая гаруй ам.доллар болсон байна. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь нийт даатгуулсан үнэлгээний 60 хувийг дотооддоо давхар даатгаж ажиллах юм.

Хөдөө аж ахуйн хүнд машин механизм, тоног төхөөрөмж даатгах ажлын анхлан даатгагч компани болох “Ард даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК-иудтай байгуулсан давхар даатгалын слип /баталгааны/ гэрээнд улирал бүр тооцоо нийлэхээр тусгасан. Уг тооцоог 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар нийлсэн ба нийт 8 тариалан эрхлэгч 662,157,698.17 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж даатгаснаас 1,986,469.48 төгрөгийн хураамж цугларч, түүнээс 953,505.35 төгрөг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дансанд шилжиж орсон байна.

“Ди Би Эм лизинг” ХХК болон “Тариалан эрхлэгчдийг дэмжих сан”, “Монгол даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК -тай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр уулзалт зохион байгуулав. Уг уулзалтаар “Тариалан эрхлэгчдийг дэмжих сан”-тай гэрээ байгуулж газар тариалангийн техник, тоног төхөөрөмж авсан тариалан эрхлэгч нарын нэгдсэн семинарыг 2018 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион явуулахаар төлөвлөв. Семинарын хүрээнд тариалан эрхлэгч нарт лизингээр авсан тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн даатгал, даатгалын эрсдэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг сэдвээр сургалт хийх бөгөөд даатгалд хамрагдаагүй тариалан эрхлэгчидтэй даатгалын гэрээ байгуулах зорилготой болно.

### **3.4. Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах судалгаа**

### Үндэсний давхар даатгалын компаниудын талаарх судалгаа

Үндэсний давхар даатгалын компанитай орнуудын давхар даатгалын туршлага, давхар даатгах даатгалын хэлбэрүүдийн харьцуулсан судалгааг хийсэн. Үүнд: Филиппин, Энэтхэг, Солонгос, Беларус, ОХУ, БНКаЗУ зэрэг улсууд багтсан болно. Мөн Дэлхийн банк, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж байгаа Олон салбарт техникийн туслалцаа үзүүлэх төслөөс 2014 онд гаргасан Монголын даатгалын зах зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах болон давхар даатгалын чадавхыг хөгжүүлэх, техник эдийн засгийн үндэслэлтэй /ТЭЗҮ/ танилцаж, бусад хөгжиж буй улсын жишээ, туршлагыг судалсан болно. Үүний үндсэн дээр Монгол Улсад нэвтрүүлэх Үндэсний давхар даатгалын компанийн хэрэгжүүлбэл зохих ажил, чиглэлүүдийг тодорхойлсон.

БНКаЗУ, ОХУ, Беларус, БНСУ, Филиппин, Энэтхэг, БНХАУ зэрэг орнуудын Үндэсний давхар даатгалын компанийн хууль эрх зүйн орчин болон компани байгуулах болсон шалтгаан, бусад туршлагыг судалсан. Эдгээр улсуудын хувьд гадагш гарах валютын урсгалыг багасгах, дотоодын даатгалын зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх, давхар даатгалын нэгдсэн системийг бий болгох, даатгалын салбараа тэлэх зэрэг үндсэн зорилготой байсан. Дээрх улсууд эхний ээлжид төрийн өмчит давхар даатгалын компани байгуулан хуулийн хэрэгжилтийг гүйцэтгүүлж байсан ба яваандаа хувийн хөрөнгө оруулалтын оролцоог татан оруулсан байна.

АКСКО /“АХСО”/ даатгалын мэдээллийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанийн олон улсын даатгалын салбарын судалгааны байгууллагаас гаргасан Монгол Улсын даатгалын зах зээл, давхар даатгалын тогтолцоо хөгжүүлэх боломжийн талаар бичсэн тайланг судалж, орчууллаа.

### Үндэсний давхар даатгалын компани байгуулах хууль эрх зүйн орчны судалгаа

Олон улсын хууль эрх зүйн орчин, хууль тогтоомжийн зохицуулалтыг харахад Үндэсний давхар даатгалын компанийн эрх зүйн зохицуулалтыг Беларус Улс Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулан Даатгалын үйл ажиллагааны тухай хуулиар, ОХУ Даатгалын байгууллагын тухай хуулиар, БНСУ Үндэсний давхар даатгалын корпорацийн тухай хууль, Даатгалын тухай хуулиар тус тус зохицуулдаг байна.

Хуулийн төслийн урьдчилсан тандан судалгаатай танилцаж, Үндэсний давхар даатгалын компани байгуулахдаа шинэ хуулийн төсөл батлуулах эсвэл даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн байдлыг бий болгох гэсэн хоёр сонголтыг харьцуулан судлан, хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан ажиллалаа.

#### *а. Шинэ хуулийн төсөл боловсруулах чиглэлээр*

Олон улсын судалгааг үндэслэн Үндэсний давхар даатгалын компани байгуулах тухай хуулийн төсөл боловсруулж Монгол Улсын давхар даатгалын тогтолцооны талаар харьцуулсан судалгааг боловсруулан, танилцуулга хийсэн. Үндэсний давхар даатгалын компанийн тухай хуулийн төслийг урьдчилан тандах судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалаар эхний байдлаар боловсруулж дууссан. Уг хууль нь 7 бүлэг, 24 зүйлээс бүрдэж байгаа ба Үндэсний давхар даатгалын компани байгуулах, үндэсний давхар даатгалын тогтолцоог сайжруулах, нэгдсэн систем бий болгох үндсэн зорилготой. Хуулийн төслийг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзан үзэв. Үүнд:

- Хуулийн үндсэн үзэл санаа, нэр томьёо, даатгал болон давхар даатгалын харилцааг хамруулах;
- Хуулийн төсөлд тусгагдаж буй санаа нь бусад хуультай нийцсэн, эс нийцсэн бол тухайн хуульд өөрчлөлт оруулах, нэмэх асуудлыг авч үзсэн;
- Олон улсын туршлага бусад ижил төстэй даатгалын тогтолцоотой орны хуулийн үзэл санааг тусгах;

- Даатгалын тухай хуулиас гадна холбогдох бусад хуулийн талаарх мэдлэг мэдээллийг ашиглах;

Үндэсний давхар даатгалын компанийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг

1. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага
  - 1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага
  - 1.2.Практик үндэслэл, шаардлага
2. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ
3. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар
4. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн танилцуулсан тухай гэсэн 4 дэд сэдвийн хүрээнд эхний байдлаар боловсрууллаа.

Даатгалын салбарын 2011-2015 онуудын тайланд үндэслэн даатгалын хэлбэр тус бүрээр хураамж, нөхөн төлбөрийн харьцаа, үнэлгээнээс тооцоолж эхний ээлжид давхар даатгах даатгалын хэлбэрүүдийг тодорхойлсон. Үүнд: Малын индексжүүлсэн даатгал, тариалангийн даатгал, хөрөнгийн даатгал, барилга угсралтын даатгал, хариуцлагын даатгал, ачааны даатгал зэрэг орно. Даатгалын хэлбэр тус бүрийн олон улсын давхар даатгал руу гаргах нийт хариуцлагын тодорхой хувийг Үндэсний давхар даатгалын компани хариуцах бөгөөд тус хувийг Сангийн яамнаас баталж байхаар хуулийн төсөлд тусгасан.

Үндэсний давхар даатгалын компанийн эхний ээлжид хариуцах даатгалын хэлбэрүүд болох хөрөнгө, хариуцлага, ачаа тээвэр, барилга угсралтын даатгалын хэлбэрийн олон улсын давхар даатгагчид шилжүүлж буй нийт эрсдэлийн 10 хувийг даатгахаар тооцоолон үүсгэх сангуудын тооцооллыг хийсэн. Үүнд: Орлогод тооцоогүй хураамжийн нөөц, учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц, учирч болзошгүй хохирлын нөөц сан, мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан зэргийг тооцож үзээд Үндэсний давхар даатгалын компани байгуулагдахад нэмэлтээр 12.3 тэрбум төгрөгийн хөрөнгө хэрэгтэй болохыг тооцоолов.

#### *б.Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр*

Үндэсний давхар даатгалын компанийн эрх зүйн байдлыг сайжруулах ажлын хүрээнд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэнтэй 9 дүгээр сарын 11-ний өдөр уулзалт зохион байгуулж, Үндэсний давхар даатгалын компанийн тухай хуулийн төслийн урьдчилан тандах судалгааг сайжруулан, Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар ярилцан, судалгаа хийв. Даатгалын тухай хуулийн Хоёрдугаар бүлэг /Төрөөс даатгалын үйл ажиллагааг зохицуулах/, Есдүгээр бүлэг /Давхар даатгал/-т гол заалтуудыг тусгаж Үндэсний давхар даатгалын компанийн эрх зүйн чадамжийг бүрдүүлэх боломжтой байна гэж үзсэн.

Үндэсний давхар даатгалын компанийн эрх зүйн байдлыг Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт болгож оруулахаар хуулийн нэмэлт өөрчлөлтийг эхний байдлаар боловсруулав. Даатгалын тухай хуульд Үндэсний давхар даатгалын компанийн эрх зүйн байдлыг нэмэлт өөрчлөлтөөр оруулснаар холбогдох хууль, журам зааварт дагаж ямар өөрчлөлт гарч болох хууль эрх зүйн орчныг судалсан.

Үндэсний давхар даатгалын тогтолцоо, эрх зүйн орчныг бий болгох ажлын тайланг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэнд хүргүүлэв. Тайланд:

- Олон улсын давхар даатгалын компаниудын судалгаа, тэдний эрх зүйн орчин;
- Үндэсний давхар даатгалын тогтолцоо бий болгох дотоодын хууль, эрх зүйн үндэслэл судалгаа;

- Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгаа;
- Хуулийн төсөл, үзэл баримтлал, хуулийн танилцуулга;
- Үндэсний давхар даатгалын компанийн үйл ажиллагааны цар хүрээг урьдчилан төлөвлөх, хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэрэг орсон болно.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2018-2020 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг холбогдох ажилтнуудын хийсэн судалгаа, тооцоололд үндэслэн СЗХ-ны “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын дагуу нэгтгэн боловсруулсан.

Компанийн 2018-2020 онд хэрэгжүүлэх “Стратеги төлөвлөгөө”-г 3 бүлэг 10 сэдвийн хүрээнд боловсруулан гаргав. Уг төлөвлөгөөнд компани Үндэсний давхар даатгалын компани болон өргөжих, цаашид давхар даатгах даатгалын хэлбэрүүд, бүтээгдэхүүний судалгаа, хөрөнгө оруулалтын өгөөж зэргийг тусгасан.

### **3.5. Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүний сурталчилгаа**

МИД-ын 2015, 2016 оны борлуулалтын тайланг англи хэл рүү орчуулж, компанийн цахим хуудсан дээр байршууллаа. Компанийн мэдээллийн самбарыг шинэчлэн, холбогдох мэдээллийг байршуулав.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн англи хэл дээрх танилцуулгыг шинэчлэн, гадаадын төлөөлөгчдөд болон компанийн ажилтнуудын ажлын хэрэгцээнд зориулан хэвлэн бэлтгэсэн.

Компанийн цахим хуудас болон нүүр ном /фэйсбүүк/-ын хуудсыг холбоотой ажиллуулж байна. Бэлдсэн мэдээ мэдээллээ монгол, англи хэлээр бэлтгэн оруулж байна. Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан бүтцийн бүдүүвч зургийг шинэчлэн зурж, англи, монгол хэлээр бэлтгэн цахим хуудсанд байршуулав.

“Улсын аварга малчин”-аар шалгарсан даатгалд хамрагдсан Архангай аймгийн малчин Д.Ганзориг, Баян-Өлгий аймгийн малчин А.Бахытбек, Баянхонгор аймгийн малчин Л.Баттөмөр, Булган аймгийн малчин Б.Буянтогтох, Говь-Алтай аймгийн малчин Ц.Батбямба, Говьсүмбэр аймгийн малчин Л.Батнасан, Дорноговь аймгийн малчин Ж.Бүрнээбаатар, Дундговь аймгийн малчин Б.Баасан нарт “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс “Шилдэг даатгуулагч”-ийн батламж гардууллаа.

“Малчин” болон “Сүлд” телевизтэй 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгууллаа. Гэрээний хугацаанд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт, малчдад сурталчилсан. Мөн шаардлагатай тохиолдолд орон нутгийн телевизүүдтэй холбоо тогтоон ажиллалаа. Гүйцэтгэх захирлын нийт малчид, хамтран ажилладаг байгууллага болон иргэдэд зориулсан цагаан сарын мэндчилгээг бэлтгэн “Малчин” болон “Сүлд” телевизээр түгээв.

Удирдлагын ярилцлагын цагийг товлох ажлын хүрээнд улирал бүр “Блүүмберг” телевизийн 30 минутын ярилцлагын цагаар компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүн болон шинэ бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгч байлаа. Мөн “Монгол” телевиз “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөрөөрөө газар тариалангийн даатгалын талаар мэдээ бэлтгэж байгаатай холбогдуулан Гүйцэтгэх захиралтай даатгалын ач холбогдол, давхар даатгалын компанийн үйл ажиллагааны талаар ярилцсан.

Монгол Улсын Үндэсний давхар даатгалын компанийн тухай хуулийн төсөл, Тариалангийн даатгалын тухай хууль, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, МИД-ын 2016 оны борлуулалтын тайлан, Худалдааны

зээлийн даатгалын тухай семинарын танилцуулга, тайлан дээр бичигдэх удирдлагын мэндчилгээ, Нидерланд Улсын Гааг хотод худалдааны даатгалын талаар олон улсын Худалдааны зээлийн даатгал ба баталгааны академи /“STECIS”/-иас зохион байгуулсан сургалтын тайлан, Олон улсын давхар даатгалын Катар Ре /“Qatar Re”/ компанитай байгуулах Харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн нэгж рүү илгээх хураангуй тайлан, ерөнхий дүгнэлт зэргийг англи хэл рүү орчуулан бэлтгэсэн.

Компанийн 2016 оны жилийн эцсийн тайланд оруулах даатгалын салбарын тоо, мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулалт хийж, монгол, англи хэл дээр агуулгыг боловсруулж, мэдээлэл, зургуудыг нэгтгэн гаргасан. Компанийн жилийн тайланг хэвлүүлэхээр хэвлэлийн компаниудын үнийн саналыг авч, “Улаанбаатар принт” ХХК-ийг сонгон англи, монгол хэл дээр нийт 1,000 ширхгийг хэвлүүллээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 04/31 дугаар тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017” сэдэвт өдөрлөгт оролцох бэлтгэл ажлыг хангах, байгууллагаа сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж, 4 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд “Тэнгэр плаза” төвд зохион байгуулагдсан өдөрлөгийн арга хэмжээнд амжилттай оролцлоо. Өдөрлөгийн үеэр нийт 1,000 гаруй хүнд үйлчлэн компанийн үйл ажиллагаа болон даатгалын бүтээгдэхүүний ач холбогдлыг танилцуулав. Иргэдийн хувьд газар тариалангийн даатгал болон экспортын даатгалын бүтээгдэхүүний талаарх мэдээллийг илүү дэлгэрэнгүй лавлаж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-тай хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байв.

Мөн Сүхбаатарын талбай дээр 2017 оны 6 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Сангийн яамны нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанд амжилттай оролцлоо. Өдөрлөгийн үеэр тус компанийн үндсэн даатгалын бүтээгдэхүүн болох Малын индексжүүлсэн даатгал, Улаанбуудайн даатгал болон Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хамтын ажиллагаатайгаар зохион байгуулагдаж буй “Экспортыг дэмжих төсөл”-д давхар даатгалын компанийн хувьд худалдааны даатгалын тал дээр ажиллаж байгаа тухай мэдээ мэдээллийг иргэдэд өгч, хэвлэмэл тараах материал /брошур/, сонин, танилцуулгыг сонирхсон хүмүүст тараасан.

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний танилцуулгыг “Тариалан” сэтгүүлийн 2017 оны 1 дүгээр улирлын дугаарт нийтлүүллээ.

ХХААХҮЯ-аас үр үржүүлэх тусгай зөвшөөрөл авсан 11 аж ахуй нэгжийн улаанбуудайн талбайд үзлэг хийж гангийн эрсдэл учирсан гэж урьдчилсан байдлаар гарсан ч нийт даатгуулсан аж ахуйн нэгжүүдээс 4 нь нөхөн төлбөр авахаар болсон юм. Тариалсан газар дээр нь очин нэвтрүүлгийн зураг авч тариаланчдаас ярилцлага авсан. Мөн Андеррайтингийн газрын дарга, андеррайтер, агрономич нарын газар дээр ажиллаж байгаа дүрс, яриаг бэлтгэн нэвтрүүлэгт ашиглахад бэлэн болголоо. Тариалангийн нэвтрүүлгийг өөрсдийн компанийн цахим хуудас болон нүүр ном /фэйсбүүк/-ын хуудсанд тавьсан.

### **3.6. Ажилтнуудыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг**

Компанийн 2017 онд зохиогдох “Дотоод сургалтын төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөний дагуу 01 дүгээр сард Бизнес хөгжил, төслийн газар “Та экспорт хийхэд бэлэн үү”, 02 дугаар сард Санхүү, удирдлагын газар “Дотоод ажил”, “Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт”, 3 дугаар сард Андеррайтингийн газар “Тариалангийн даатгалын бүтээгдэхүүн, түүний хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, 4 дүгээр сард Бизнес хөгжил, төслийн газар “Даатгалын андеррайтингийн үйл



ажиллагаа”, оффис түрээслүүлэгч “Булнайн Ар” ХХК “Галын аюулгүй байдлын тухай”, 5 дугаар сард Экспортын даатгалын газар “Экспортын даатгалын бүтээгдэхүүний танилцуулга”, 6 дугаар сард Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, Андеррайтингийн газар “Давхар даатгалын үндсэн ойлголт”, 9 дүгээр сард Санхүү, удирдлагын газар “Цаг үеийн ажлын талаар”, 10 дугаар сард Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар “Нөхөн төлбөрийн тооцоолол, нөхөн төлбөрийн олголт”, 11 дүгээр сард Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл “Оффисын ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдэд тавигдах стандарт, шаардлага” сэдвээр тус бүр дотоод сургалтыг зохион явууллаа. “Дотоод сургалтын төлөвлөгөө”-ний биелэлт 92.5 хувьтай байна.

Сургалтыг танилцуулга /presentation/ хэлбэрээр бэлтгэн ажилтнуудын дундын мэдээллийн сан /Share/-д “Дотоод сургалт” цэсэд байршуулж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, өнөөгийн байдал, анхаарах асуудал” сэдэвт сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт Санхүү, удирдлагын газрын дарга, дотоод хяналтын ажилтан нар оролцож, саналаа илэрхийллээ.

Хууль зүйн яамнаас 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах” сэдэвт сургалтад Бизнес хөгжил, төслийн газрын ажилтнууд, Ерөнхий хуульч нар хамрагдав. Тус сургалтаар хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барихдаа ямар судалгаануудыг хэрхэн хийх, хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах явцуудын талаарх мэдлэгийг олж авлаа. Энэ сургалтаар олж авсан мэдлэгээ компанийн холбогдох ажилтнуудад мэдээлэл хийж, танилцуулсан.

НҮБ, Монгол Улсын Засгийн газар, ОБЕГ-аас хамтран зохион байгуулсан “Монгол Улсын гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны шинэчлэл” үндэсний хэлэлцүүлэгт оролцож, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулга /2017.02.02/-ын танилцуулга, түүнийг хэрэгжүүлэх зарчим, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, гамшгийн эрсдэлийн удирдлага, гамшгийн даатгалын талаар мэдээлэл цуглуулав.

МҮХАҮТ /Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим/-аас Олон улсын худалдааны төв /ИТС/-тэй хамтран зохион байгуулсан 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн “Стратегийн барааны худалдааны менежмент, олон улсын чиг хандлага” сэдэвт сургалтад Бизнес хөгжил, төслийн газрын ажилтнууд хамрагдав.

2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас “Зохистой хөдөлмөр-2017” аяны хүрээнд зохион явуулсан сургалтад Санхүү, удирдлагын газрын дарга, Дотоод хяналтын ажилтан нар хамрагдлаа. Сургалтаар Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар, ажил олгогчийн эрх, үүргийн талаар мэдлэг олгосон.

Мөн 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан Сүхбаатар дүүргийн Ажил олгогчдын 4 дүгээр чуулганы үйл ажиллагаанд компанийн Хөдөлмөрийн маргаан таслах комиссын төлөөлөл оролцлоо.

АНУ-д 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс 25-ны өдрүүдэд Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга хөгжиж буй орны төрийн албаны болон төрийн секторын оролцогчид хамрагдсан “Олон улсын байгууллагын менежмент” сургалтад оролцож, удирдлагын түвшинд хөгжүүлэх шаардлагатай ур чадвар болох байгууллагын



удирдах, шийдвэр гаргах, боловсон хүчнийг хөгжүүлэх, хариуцлагын тогтолцоо, тайлагнах стандартууд болон үр ашигтай харилцаа холбоо тогтоох, хэлэлцээ хийхтэй холбоотой хичээлүүдийг судалсан.

ХХААХҮЯ, Герман Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуйн төсөл”, ХААИС, Төв Азийн хөрс судлалын холбоо хамтран 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан Тариалангийн талбайн хөрсний тогтвортой ашиглалт, хамгаалалт зөвлөгөөнд компанийн агрономич оролцсон.

Мөн Монголын агрономичдын холбооноос 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад компанийн агрономич хамрагдан тэргүүлэх зэргийн сертификат авсан.

Монголын мал амьтан хамгаалал, хөгжлийн холбооноос 2017 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан “Мах, сүүний эрчимжүүлсэн үхрийн ферм хөгжүүлэх” сэдэвт сургалтад Дэд захирал, эрсдэлийн шинжээч, даатгалын шинжээч нар хамрагдав. Сургалтаар сүүний үхрийн тэжээллэг маллагаа, мөн тугал, өсвөр үхрийн болон дунд зэргийн насны үхрийн тэжээллэг маллагаа, махны үхрийн аж ахуй, сүүний салбарт тулгамдаж буй асуудал, эрчимжүүлсэн мал аж ахуйн үндсэн эрсдэлүүд, стандарт, тэжээлийн нэгдсэн хангамж төвийн судалгааны талаар ярилцав.

ОБЕГ болон ХБНГУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх судалгааны төсөл”-тэй хамтран 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Гамшгийн эрсдэлийн даатгалын хэрэгцээ, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт форумд оролцлоо. Тус форумд Андеррайтингийн газрын дарга “Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулахад даатгалын оролцоо” сэдэвт илтгэл тавьсан.

Даатгалын зуучлагчийн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион явагдсан сургалтад “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль эрх зүйн ойлголт, гэрээ хийх арга зүй” сэдвээр Андеррайтингийн газрын дарга сургалт хийсэн.

## **ДӨРӨВ. ЭКСПОРТЫН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН**

### **4.1. Экспортын даатгалын зах зээл дэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа**

Монгол Улсын уул уурхайн бус салбарт экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа болон эрхлэхээр зорьж буй аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой Экспортын даатгалын шинэ бүтээгдэхүүнийг боловсруулах ажлыг хийж байна. Үүнд:

- Экспортын мэдээллийг боловсруулах чиглэлээр экспортын бараа бүтээгдэхүүн болон дотоодын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, экспортын салбар бүрээр ангилсан дэлгэрэнгүй судалгаа хийсэн.
- Экспортын зах зээлд оролцогчдын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, мэдээлэл цуглуулах ажлыг хийж байна. Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасны дагуу Экспортын даатгалын газар /цаашид байгуулагдах Экспортын зээлийн агентлаг/ нь хураамжийн хувийг тогтоож, шаардагдах нөөцийн түвшин, тооцооллыг гаргах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг бий болгох юм. Экспортын даатгалын агентлаг байгуулагдах хүртэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах ажил хийгдэх бөгөөд агентлаг байгуулагдсаны дараа даатгалын гэрээ тус бүрийн эрсдэлийн хүчин зүйлсийг авч үзсэн буюу илүү нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд ашиглагдах мэдээллийг оруулж, баяжуулан ажиллана.
- Экспорт, гадаад худалдаа болон экспортын зээлийн даатгалтай холбогдох хууль тогтоомжуудыг нэгтгэн судалж, үндэслэл бүхий холбогдох зүйл заалтуудыг нэгтгэв.

Экспортын даатгалын шинэ бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд амжилттай нэвтрүүлэх зорилгоор Олон улсын зөвлөхийн тусламжтайгаар “Зах зээлийн судалгаа” хийх гэж байгаа бөгөөд уг судалгаанд ашиглах суурь судалгаа, өгөгдлийг цуглуулах зорилгоор Нидерланд Улсын Засгийн газрын байгууллага Нидерланд Улсын ахмад мэргэжилтнүүдийн ТББ /“PUM senior experts”/-ын мэргэжилтэн Яап Шуйтмэкрийн хамт 2017 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 31-ний өдрүүдэд Монгол Улсад жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй уул уурхайн бус буюу хүнс, ноос ноолуур, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, мах, мод модон эдлэл, гоо сайхан, арьс ширний салбарт ажиллаж буй 30 гаруй аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүд, холбоод, орон нутгийн удирдлагуудтай уулзалт хийж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зах зээлийн суурь судалгааг хийж, тайланг нэгтгэн гаргав.

Зах зээлийн судалгааг хийх, өгөгдлийг цуглуулах зорилгоор Гаалийн ерөнхий газарт хамтран ажиллах хүсэлт илгээснээр экспортлогч аж ахуй нэгжийн мэдээллийг авлаа. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс гадаад худалдаа, санхүүгийн байдал, экспортын даатгалын талаар асуух санал асуулгын хуудсыг бэлтгэж, уг санал асуулгын загвараар мэдээлэл өгсөн аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэсэн.

Монгол Улсын бизнес регистрийн санд бүртгэлтэй экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулах гэж буй 126,560 аж ахуйн нэгж байгаагаас 64,301 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба 84.3 хувийг жижиг, дунд үйлдвэрийн салбарынхан эзэлж байна. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид ДНБ-ийн 17.8 хувь, экспортын бүтээгдэхүүний 2.3 хувийг үйлдвэрлэж байна.

Экспортлогч байгууллагуудын үнэн зөв мэдээллийг цуглуулах зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин, удирдан ажилладаг 8 холбоодтой уулзалт зохион байгуулан, хамтран ажиллах санамж бичиг байгуулж байна. Холбоодоос авсан мэдээлэлд үндэслэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээллийг авч, судалгааны ажлыг эхлүүлсэн. Мэдээллийн нэгдсэн сангийн ерөнхий мэдээллийг энэхүү судалгаагаар баяжуулна.

Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзан экспортыг дэмжих төслийн талаар танилцуулга хийж, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг экспортлогч аж ахуйн нэгжүүд болон экспортлохоор зорьж буй аж ахуйн нэгжүүдийн талаар мэдээлэл авав.

ХХААХҮЯ, Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газар, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооноос хамтран зохион байгуулсан “Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн хэлэлцүүлгийн арга хэмжээнд Бизнес хөгжил, төслийн газрын дарга оролцож, одоогийн хэрэгжиж буй хууль болон хуулийн төслийн үзэл баримтлалыг судлан ажилласан.

Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Холбоо, Монголын Ноос Ноолуурын Холбоо “Мишээл” групптэй хамтран 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Мишээл Экспо”-д зохион байгуулсан “Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2017” үзэсгэлэн яармагт оролцож, “Дархан минж” ХХК, “Дархан нэхий” ХХК, “Мон-Ирээдүй” ХХК, “Эс Ар Би” ХХК, “Уужин” ХХК, “Гоёл” ХХК, “Гоёо” ХХК, “Хайтан” ХХК зэрэг 10 гаруй аж ахуйн нэгжүүдтэй уулзаж, хэлэлцүүлэг хийлээ.

Экспортын даатгалын зах зээлийг судалж, хэрэглэгчдэд тохирсон шаардлагатай бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх зорилгоор ХБНГУ-ын Оффенбург их сургуулийн Олон улсын санхүү, эдийн засаг бизнесийн профессор ноён Андреас Класен 11, 12 дугаар сард техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Олон улсын зөвлөх Андреас Класены 11 дүгээр сарын эхний айлчлал, 12 дугаар сарын 2 дахь удаагийн айлчлалд зориулж төслийн зорилтот бүлгүүдтэй хийх уулзалтын товыг урьдчилан гаргаж, баталгаажуулан томоохон арилжааны банкуудын худалдааны санхүүжилт хариуцсан газрын төлөөллүүд, арьс шир, ноос ноолуур, хүнсний салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд, Гадаад харилцааны яам, Сангийн яам, ХХААХҮЯ, Зээлийн батлан даалтын сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Экспортыг дэмжих төслийн нэгж, МҮХАҮТ зэрэг байгууллагуудын төлөөллүүдтэй 20 орчим уулзалтыг зохион байгуулсан. Зорилтот бүлгүүдээс “Санал асуулга-2” авах ажлын хүрээнд 12 арилжааны банк, 25 аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй жагсаалт гаргаж, тэдгээртэй утсаар, цахим шуудангаар холбогдож, санал асуулгын хуудсыг цахим шуудангаар явуулж судалгаа авч, олон улсын зөвлөх Андреас Класенд нэгтгэж өглөө. “Санал асуулга-2”-ыг цуглуулан нэгтгэж боловсруулан матрикс хүснэгт гаргав.

Зах зээлийн судалгаа хийж, цаашид байгуулагдах охин компанийн эрх зүйн байдлыг тодорхойлоход зөвлөмж өгөх олон улсын зөвлөх Андреас Класен Экспортын даатгалын газрын ажилтнуудтай хамтран ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэн дараах 2 тайланг бэлтгэв. Үүнд:

1. Экспортын даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийг тодорхойлох;
2. Зах зээлийн эрэлтэд тохирсон бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлийг тодорхойлох;

Олон улсын зөвлөх Андреас Класены эдгээр тайлангуудын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, экспортын даатгалын охин компанийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, эрхлэх бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын өсөлт, үйл ажиллагааны зардал, хураамж, нөхөн төлбөр, ашиг алдагдлын тооцоолол дээр хамтран ажиллалаа.

Экспортын даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг өргөжүүлэхтэй холбогдуулан мэдээлэл технологийн салбарын буюу оюуны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, аж ахуй нэгжүүдийн талаар холбогдох мэдээ мэдээллийг бэлдэх зорилгоор Мэдээлэл, Технологийн Үндэсний паркийн холбогдох ажилтантай холбогдож, мэдээлэл авч байна. Монголын програм хангамж, үйлдвэрлэгчдийн холбооны талаар судалгаа хийв. Монголын програм хангамжийн компаниуд олон улсын зах зээлд контент програм хангамжаа гаргахыг зорьдог. Гэвч тухайн зах зээлийг мэдэхгүй, хэрэглэгчийн соёлыг мэдэхгүйгээсээ болоод маш их хэмжээний цаг хугацаа алдаж, мөнгө санхүүгийн алдагдалд хүрдэг. Үүнээс улбаалаад тодорхой хугацааны дараа шантардаг. Иймд манай компаниуд зах зээлээ мэддэг, мэдэрдэг, тухайн зах зээлдээ нэр хүндтэй, өөрийн гэсэн хэрэглэгч, харилцагчтай болсон компаниудтай хамтарч бүтээгдэхүүнээ гаргах нь энэ эрсдэлээс сэргийлэх боломжтой болгох тул найдвартай худалдан авагчтай болохыг экспортлогчид олон улсад бараагаа худалдах чухал хөшүүрэг гэж үзэж байна. Экспорт хийдэг болон хийх боломжтой мэдээлэл технологийн салбарын зарим төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах хүсэлт тавиад холбогдох ажилтнаас хариу ирэхийг хүлээж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй Олон Улсын түнш байгууллагууд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг судалж, донор байгууллагуудын талаар мэдээлэл бэлтгэв. Тухайлбал, Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны Жижиг Дунд Бизнесийг Дэмжих Баг нь төрөл бүрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнесийг өөрчлөн хөгжихөд нь тусалж чадах дотоод болон гадаад зөвлөхүүдтэй холбож өгдөг. Мөн Зээлийн батлан даалтын сан Азийн хөгжлийн банкны 60.0 сая ам.долларын санхүүжилттэй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байгаа ба энэхүү төсөл нь зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байгаа шалгуур

хангасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 10 хүртэл жилээс хэтрэхгүй хугацаатай, 30-60 хувийн батлан даалттай, 1.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй хэмжээтэй зээлийг арилжааны банк болон Зээлийн батлан даалтын сангийн хамтарсан эх үүсвэртэйгээр олгож байна.

Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Монгол банкнаас сар болгон гаргаж буй гадаад худалдаа, экспорт, импортын мэдээллийг судлан, судалгаа мэдээлэл боловсруулан ажиллалаа.

#### **4.2. Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг тодорхойлох үйл ажиллагаа**

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаа явуулж буй Экспортыг дэмжих төсөлд Дэлхийн банкны мэргэжилтэн Арнауд Дорнел ирж ажилласан ба Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнуудтай хамтран ажиллаж Экспортыг дэмжих төслийн хүрээнд хийгдэх экспортын даатгалын бүтээгдэхүүний бүтцийн тухай ярилцав. Экспортын даатгалын хувьд тээвэрлэлтийн өмнөх /pre-shipment/, тээвэрлэлтийн дараах /post-shipment/ гэсэн хоёр төрлийн даатгал байж болох талаар ярилцав.

Зах зээлийн судалгаа хийж, цаашид байгуулагдах охин компанийн эрх зүйн байдлыг тодорхойлоход зөвлөмж өгөх Олон улсын зөвлөх Андреас Класен экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, экспортын хэмжээг өсгөхөд тулгараад буй саад бэрхшээлүүдэд үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнээр дамжуулан төслийн эхний жилүүдэд дараах үндсэн хоёр асуудлыг шийдвэрлэж болох талаар зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Бүтээгдэхүүн боловсруулалт буюу үйлдвэрлэлийн үе шатанд барьцаа хөрөнгө шаардахгүйгээр эргэлтийн хөрөнгийн зээл авах бололцоог бий болгох;
2. Нийлүүлэгчийн зээлээр дамжуулан нээлттэй дансаар худалдаа хийсэн тохиолдолд зээлийн хугацааг сунгаж төлбөрийн нөхцөлийг сайжруулснаар Монгол Улсын экспортлогчдын өрсөлдөх чадварыг сайжруулах

Дээрх хоёр асуудлыг шийдвэрлэж, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, экспортын хэмжээг өсгөхийн тулд тээвэрлэлтийн өмнөх санхүүжилт /Pre-shipment Financing/-ийн, тээвэрлэлтийн дараах санхүүжилт /Post-shipment Finance/-ийн буюу нийт хоёр бүтээгдэхүүнийг эхний жилүүдэд зах зээлд нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Тээвэрлэлтийн өмнөх санхүүжилт:

- Эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн даатгал /Working capital insurance/-Экспортлогч эргэлтийн хөрөнгийн даатгалын гэрээг барьцаалан банкнаас эргэлтийн хөрөнгийн зээл авах бөгөөд экспортлогч буюу зээлдэгч зээлээ төлөхгүй байх эрсдэлээс банк болон бусад санхүүгийн байгууллагыг хамгаална.

Тээвэрлэлтийн дараах санхүүжилт:

- Богино хугацаат нийлүүлэгчийн зээлийн даатгал /Short-term Supplier Credit Insurance/-Экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зардлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална.

Олон улсын туршлага болон Монгол Улсын зах зээлийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн Олон улсын зөвлөх Андреас Класен “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Экспортын даатгалын охин компани нь Засгийн газрын тусгай агентлаг хэлбэрээр байгуулагдах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгсөн. Сонгосон экспортын даатгалын бүтээгдэхүүний гарын авлага, дэлгэрэнгүй бичиг баримтыг боловсруулж дуусгав.

Монголын Банкны холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хамтран зохион байгуулсан “Жижиг дунд бизнесийн санхүүгийн хүртээмж-2017” форумд оролцож,

жигжиг дунд бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тулгарч байгаа асуудлыг тодорхойлох, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, санхүүжилтийг илүү хүртээмжтэй уян хатан болгох талаар арилжааны банкууд, холбогдох төрийн байгууллагууд болон олон улсын түнш байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсож, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөө зөвлөмж боловсруулж байгаа талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлэгт оролцлоо.

Хэлэлцүүлгийн үеэр компанийн үйл ажиллагаа, ялангуяа Экспортыг дэмжих төслийн хүрээнд уул уурхайн бус салбарын жигжиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийг эрсдэлээс хамгаалах, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор тус компанийн Экспортын даатгалын газар экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн болох экспортын даатгалын бүтээгдэхүүн боловсруулан ажиллаж байгаа тухай мэдээлэл өглөө.

#### **4.3. Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа**

Монгол Улсын Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэх, гадаад худалдааг дэмжих зорилтын хүрээнд уул уурхайн бус салбарын жигжиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд төрөөс туслалцаа үзүүлэх, тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд нэвтрэх нөөц бололцоог өргөжүүлэх, суурь бүтцийг бэхжүүлэх гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгоход чиглэсэн Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан. Уг төслийн зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Гадаад бодлогын үзэл баримтлал, Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Эдийн засгийг сэргээх хөтөлбөртэй зорилгын хувьд нийцэж байгаа юм. Монгол Улсад шинээр байгуулагдах Экспортын зээлийн агентлагийн үйл ажиллагаа, байгуулагдах үндэслэлийг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”-т тусгасан байдаг.

Экспорт, гадаад худалдаа, гааль, татвар, зээлийн мэдээллийн сан болон жигжиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидтэй холбогдох хууль тогтоомжуудыг судлав.

Дэлхийн бусад улс орнуудад экспортыг дэмждэг ямар байгууллагууд байдаг талаар, хууль эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа боловсруулав. Судалгаанаас дүгнэхэд тухайн улсын экспортын орлогыг өсгөх, гадаад худалдааны алдагдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх төрөөс дэмжсэн бодлогын хүрээнд аливаа улс орнууд Экспортын зээлийн агентлагийг үүсгэн байгуулдаг. Гадаадын улс орнуудын туршлагаас харахад экспортын зээлийн даатгалын агентлагууд /цаашид “ЭЗА” гэх/ тусдаа бие даасан хуультай байх нь элбэг бөгөөд экспортын даатгалын бүтээгдэхүүний тогтвортой хөгжлийг хадгалж, урт хугацаанд амжилттай, үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад нь хууль эрх зүйн бие даасан орчин ихээхэн нөлөөлдөг байна. Эрх зүйн тогтолцоо, орчныг бүрдүүлж чадсан улс орнууд олон байдаг. Жишээ нь: Канад Улс, Норвеги Улс, Финлянд Улс болон Дани Улс зэрэг болно.

Экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа болон эрхлэхийг зорьж буй жигжиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн Зээлийн даатгалын үндэсний тогтолцоог бүрдүүлж, экспортын даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах, сайжруулах санал, зөвлөмж, төсөл боловсруулах дотоодын зөвлөх үйлчилгээний тендерийн сонгон шалгаруулалтыг зарласан.

Дэлхийн банкнаас Экспортыг дэмжих төслийг хариуцан ажиллаж байгаа Төслийн удирдагч хатагтай Улле Лохмусын ахалсан ажлын хэсэг Экспортыг дэмжих төслийн хэрэгжилттэй танилцаж, зөвлөмж чиглэл өгөхөөр Монгол Улсад 2017 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд ажиллав.



Төслийг хэрэгжүүлэх нэгж "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн Экспортын даатгалын газартай хамтран Төслийн удирдагч хатагтай Улле Лохмус, Дэлхийн банкны зөвлөх, санхүүгийн салбарын Тэргүүлэх мэргэжилтэн ноён Арнауд Дорнел нарт төслийн хэрэгжилт, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлуудаа 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Дэлхийн банкны Суурин төлөөлөгчийн газарт болсон уулзалт дээр танилцуулав.

“Экспортыг дэмжих төсөл”-ийн Дэлхийн банкны зөвлөх, санхүүгийн салбарын Тэргүүлэх мэргэжилтэн ноён Арнауд Дорнел Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 28-ны өдрүүдэд Экспортын даатгалын газартай хамтран ажиллаж, Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, салбарын талаар хийсэн судалгаа, тайлан, мэдээлэлтэй танилцан, холбогдох мэдээ баримт, манай улсын нөхцөл байдал, зах зээлийн шинж чанар дээр тулгуурлан уулзалт, семинарыг зохион байгуулж, экспортын даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, цаашдын төлөвлөгөөг хэлэлцэн хамтран боловсруулав.

Гадаадын 20 гаруй улсын экспортын даатгалын компаниудын бүтэц, үүсгэн байгуулагдсан шалтгаан, бүтээгдэхүүн болоод хэрэгжүүлэх механизм, хууль эрх зүйн орчны тухай дэлгэрэнгүй судалгаа хийлээ. /Хүснэгт 4/

Хүснэгт 4.

БУСАД ОРНУУДЫН ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БАЙГУУЛЛАГУУД					
№	Улс	Даатгал	Баталгаа	Санхүүжилт	Эхэлсэн
1	Их Британи	UKEF	UKEF	UKEF	1919 он
2	Австри	Kontrollbank (OKB)	Kontrollbank (OKB)	Kontrollbank (OKB)	1950 он
3	Япон	NEXI	NEXI	JBIC	2001 он
4	Канад	EDC	EDC	EDC	1944 он
5	Словени	SID	SID	SID	1992 он
6	Чех	EGAP	EGAP	CEB (23% EGAP)	1992 он
7	Дани	EKF	EKF	EKF	1922 он
8	Финлянд	Finnvera	Finnvera	FIDE (100% Finnvera)	1999 он
9	Франц	COFACE (хувийн)	COFACE (хувийн)	NATEXIS	1946 он
10	ХБНГУ	Euler Hermes (хувийн)	Euler Hermes (хувийн)	KfW Bankengruppe	1917 он
11	Итали	SACE	SACE	SIMEST (хувийн)	1977 он
12	Нидерланд	Atradius (хувийн)	Atradius (хувийн)	байхгүй	1925 он
13	Шинэ Зеланд	ECO	ECO	байхгүй	2001 он
14	Норвеги	GIEK	GIEK	Eksporthfinans ASA	1962 он
15	ОХУ	EXIAR	EXIAR	ROSEXIMBANK	2011 он
16	Беларус	EXIMGARANT	EXIMGARANT	байхгүй	2001 он
17	Иордан	JLGC	JLGC	JLGC	1994 он
18	БНКаЗУ	KAZAKHEXPORT	KAZAKHEXPORT	KAZAKHEXPORT	2003 он
19	Швед	EKN	EKN	SEK	1933 он
20	Швейцар	SERV	SERV	байхгүй	1934 он
21	Тайланд	THAIEXIMGARANT	THAIEXIMGARANT	THAIEXIMGARANT	1993
22	БНХАУ	SINOSURE	SINOSURE	SINOSURE	2001
23	БНЭУ	ECGC	ECGC	ECGC	1957

ОХУ-ын “Интерфакс” мэдээллийн агентлагийн үйл ажиллагааны танилцуулгыг судлав. Тус агентлаг нь бизнес, санхүү, зээлийн мэдээллийн нэгдсэн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд зах зээлийн анализ, судалгаа, эрсдэлийн удирдлагын дата баазтай бөгөөд дэлхийн



олон улс орнууд үйлчилгээг нь хүртэж байна. Спарк, спарк-маркетинг мэдээллийн программд бүртгүүлэн гадаадын худалдан авагчийн мэдээллийн хайлтын системийг судалсан.

Экспортын даатгалын охин компани үйл ажиллагаа явуулж эхлэх 2019 оноос 2021 оныг хүртэлх 3 жилийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллийг хийлээ. Үүнд: Хураамж болон нөөц сан, хөрөнгө оруулалтын орлого, үйл ажиллагааны зардал, тайлан тэнцэл, ашиг алдагдлын тайлан, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөллийг жил тус бүрээр гаргав.

#### **4.4. Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа**

Экспортын даатгалын 2017 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллав.

Компанийн ажилтнуудад мэдлэг олгох ажлын хүрээнд Голомт банкны Гадаад худалдаа, санхүүжилтийн хэлтсийн захиралтай сургалтын гэрээ байгуулан “Богино, дунд хугацаат худалдааны санхүүжилт, баримтат төлбөр тооцооны тухай” сэдэвт сургалтыг 2017 оны 4 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн байранд хийв. Уг сургалтад:

- Хил дамнасан худалдаа, түүний санхүүжилтийн үндсэн ойлголт
- Худалдааны санхүүжилтийн хэрэгслийн эрсдэлийн шатлал
- Импортын аккредитив
- Экспортын аккредитив
- Импортын санхүүжилт
- Экспортын даатгалын агентлагаар даатгагдсан зээл
- Худалдааны санхүүжилтийн эрсдэлийг хаах хэрэгслүүд зэрэг дэд сэдвүүд багтсан.

Санхүү, даатгалын чиглэлээр тусгайлсан сургалт зохион байгуулж, итгэмжлэл олгох үйл ажиллагааг эрхлэн зохион явуулдаг Мэргэшсэн даатгалын хүрээлэн /“Chartered Insurance Institute”/-ийн удирдлагуудтай Гүйцэтгэх захирал Их Британи улсын Лондон хотод 4 дүгээр сарын 02-ны өдрөөс 08-ны өдрүүдэд уулзаж, хүний нөөцийг чадавхжуулах асуудлаар хамтран ажиллахаар санал солилцов. Түүнчлэн энэхүү томилолтын хүрээнд Лондоны эдийн засгийн сургуульд зочлон мэргэжлийн сургалтуудад компанийн удирдлага, ажилтнуудыг хамруулах боломжийг нээв.

Ботсвана улсын Казане хотод 2017 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Берний холбооны Праг клуб /“Berne Union-Prague Club”/-ийн хаврын уулзалтад Бизнес хөгжил, төслийн газрын дарга оролцсоноор дэлхийн 73 орны 84 гишүүн компани бүхий олон улсад экспортын зээл, хөрөнгө оруулалтын даатгалын чиглэлээр тэргүүлэгч Берний холбооны Праг клуб /“Berne Union-Prague Club”/-д зочин байгууллагаар элслээ. Ийнхүү тус холбооны зочин байгууллага болж, уулзалтад оролцсон гишүүн байгууллагуудад Экспортыг дэмжих төсөл, үйл ажиллагааг танилцуулснаар экспортын даатгалын шинэ бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэх чиглэлээр гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл бүрдсэн.

Нидерланд Улсын Гааг хотод 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс 23-ны өдрүүдэд зохиогдсон “Худалдааны зээлийн даатгалын тухай ойлголт олгох сургалт”-нд Бизнес хөгжил, төслийн газрын ажилтнууд хамрагдлаа. Сургалтад хамрагдсанаар худалдааны зээлийн эрсдэл, худалдааны зээлийн менежмент, худалдааны зээлийн даатгалын менежмент болон зээлийн даатгалын гүйцэтгэх үүргийн уялдаа, экспортын зээлийн агентлаг, түүний зах зээлийн тухай ерөнхий ойлголт, гэрээ байгуулах, хураамж тооцоолох зарчим, андеррайтинг хийх, худалдааны зээлийн даатгалын худалдан авагчид

хийх андеррайтинг, тусгай эрсдэлийн менежмент, нэхэмжлэл, нөхөн төлбөр, давхар даатгалын тухай ерөнхий ойлголт зэрэг дэд сэдвийн хүрээнд мэдлэг эзэмшсэн.

ХХААХҮЯ-наас зохион байгуулсан Үйлдвэрлэлийг дэмжих 21:100 бодлогын хүрээнд 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцүүлэгт оролцсон.

МҮХАҮТ-аас 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион явуулсан “Стратегийн барааны худалдааны менежмент, олон улсын чиг хандлага” сэдэвт сургалтад Бизнес хөгжил, төслийн газрын ажилтнууд хамрагдлаа.

Гадаад худалдаа, төлбөр тооцооны чиглэлээр мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас зохион байгуулсан “Гадаад худалдааны санхүүжилт, төлбөрийн аргууд” сэдэвт дотоод сургалтад хамрагдав.

Экспортын даатгалын газрын шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан, маркетингийн менежер нар Экспортын зээлийн агентлагийн санхүүжилтийн талаар практикт суурилсан бодит ойлголттой болох зорилгоор “TXF Asia 2017” семинар болон сургалтад Хонг Конг Улсад 10 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрүүдэд хамрагдаж худалдан авагчийн зээлийн бүтээгдэхүүнүүд, нийлүүлэгчийн зээлийн бүтээгдэхүүнүүд, бүс нутаг, улсын эрсдэлийн ангилал, арилжааны хүүгийн түвшин, улс орон бүрийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тодорхойлолт, банкны салбар болон Экспортын зээлийн агентлагийн эрх зүйн зохицуулалтын хамаарлын талаар мэдлэг эзэмшсэн.

Серб Улсад 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд Берний холбооны Праг клуб /“Berne Union-Prague Club”/-ийн гишүүн компанийн төлөөлөгчийн хувиар Экспортын даатгалын газрын дарга Берний холбооны Праг клуб /“Berne Union-Prague Club”/-ийн жилийн уулзалтад оролцож, тус холбооны гишүүн улсуудтай экспортын зээлийн даатгалын өнөөгийн хандлага, шинэ бизнесийн хурдацтай өсөлт, түүнтэй холбоотойгоор өндөр нөхөн төлбөр, олон улсад тулгарч буй эрсдэлийн сорилтууд болон 2018 оны төсөөллийн талаар хэлэлцлээ. Уулзалтын үеэр Праг клубийн гишүүдэд Экспортын даатгалын төслийн хэрэгжилтийн талаар танилцуулсан ба бусад орнуудын Экспортын зээлийн агентлаг, экспортын даатгагчидтай үр дүнтэй хамтран ажиллах боломжийг нээх зорилгоор хоёр талт уулзалтууд зохион байгуулж, санал солилцсон.

Банк санхүүгийн академиас 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс зохион байгуулсан “Худалдааны санхүүгийн үйл ажиллагаа” /“Trade Finance operations”/ сэдэвт 3 өдрийн сургалтад Экспортын даатгалын газрын ажилтнууд хамрагдсан. Тус сургалтыг Бүгд Найрамдах Чех улсын Олон улсын худалдааны танхимын банкны асуудал хариуцсан нарийн бичгийн дарга, олон улсын зөвлөх, ноён Павел Андре удирдаж, гадаад худалдааны төлбөр тооцооны төрлүүд, UCP 600, URDG, SWIFT MT700 зэрэг олон улсын стандарт дүрмүүд, баримтат зээл, аккредитив, банкны баталгаа, бичиг баримт шалгах, бараа үйлчилгээ тээвэрлэхээс өмнөх ба дараах санхүүжилт зэрэг сэдвүүдээр практик сургалт хийж, экспорт, импорт, гадаад худалдаа, тээвэр зуучийн компаниуд, банк санхүүгийн байгууллагуудтай хэрхэн үр ашигтай хамтарч ажиллаж болох талаар зөвлөгөө өглөө.

Олон улсын давхар даатгалын СКОР /“SCOR”/ компанийн Ази номхон далайн бүсийн Худалдааны авлагын даатгал, баталгаа болон давхар даатгалын сургалтын хичээлүүдийг орчуулан судлав. Уг хичээлүүдээс Худалдааны авлагын даатгалын үнийн динамик ба эрсдэлийн удирдлага, улс орны эрсдэлийн шинжилгээ, үйлдвэрлэлийн эрсдэлийн шинжилгээ зэрэг хичээлүүдийг дотоод сургалт байдлаар зохион байгуулан судалсан.

Экспортыг дэмжих төслийн хүрээнд цахим хичээл бэлдэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт хийж, мэдээлэл хүргүүлж байна. Уг ажлын хүрээнд худалдааны зээлийн даатгалын талаар “Худалдааны зээлийн даатгалын ач холбогдол”, “Худалдааны зээлийн

даатгалын бүтээгдэхүүний төрлүүд" сэдвээр цахим хичээл бэлтгэн төслийн цахим хуудсанд байршуулсан.

#### **4.5. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагаа**

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтнуудад бизнесийн англи хэл заалгах зорилгоор Монгол дахь АИЭСЭК /AIESEC/ олон улсын ашгийн бус залуучуудын байгууллага/ байгууллага, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК хооронд хамтын ажиллагаа тогтоож, уулзалт зохион байгуулан, Харилцан ойлголцлын санамж бичгийг Монгол хэл рүү орчуулж, хамтын ажиллагааны гэрээ байгуулав. Гэрээний дагуу ирж, англи хэл заах оюутнууд хувийн шалтгаанаар Монголд ирэх боломжгүй болсон тул тодорхойгүй хугацаагаар энэхүү сургалт хойшлогдов. Компани цаашид уг байгууллагатай англи хэлний сургалт зохион байгуулж, хичээл заалгах шаардлагагүй гэж үзлээ.

ОХУ-ын “Диасофт” даатгалын програм хангамжийн компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, тэдний санал болгож буй даатгалын програмын танилцуулгын талаар судлав. 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ОХУ-ын “Диасофт” компанийн төлөөллүүдтэй /Всеволод Мартинюк-олон улсын борлуулалтын менежер, Александр Явкин-Бизнес хөгжлийн газрын захирал/ 2 дахь удаагаа уулзалт хийж, санал болгож буй програмын талаар мэдээлэл солилцож, манай компанийн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбогдуулан “Диасофт” компанийн зүгээс давхар даатгалын нэгдсэн програмын төслийг хийж боловсруулан цахим хурал хийж, танилцуулсан.

Мөн Франц Улсын Тинубу Скуэр экспортын зээлийн даатгалын агентлаг /“Tinubu Square”/-ийн зүгээс Экспортын даатгалын компанийн програм хангамжийн шийдлийн талаар цахим хурал хийв. Тус агентлаг нь банк, экспортын даатгалын компани, экспортын зээлийн агентлагуудын програм хангамжийг нийлүүлдэг бөгөөд цахим хурлаар танилцуулсан програм нь зээлийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийн андеррайтинг гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдсэн ба модуль тус бүрээр үнэлгээтэй бөгөөд хэсэгчлэн худалдан авах боломжтой юм. Монгол Улсын зах зээлд одоогоор том хэмжээний програм хангамж шаардлагагүй гэж үзэв.

Беларус Улсын Экспортын даатгалын агентлаг “БелЭксимГарант” компанийн Экспортын эрсдэлийн даатгалын газрын дарга Вероника Сидорова, Хөгжлийн банкны экспортын санхүүжилтийн газрын дарга Геннадий Хомич нартай 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр уулзалт хийж, Беларус Улс болон Монгол Улсын гадаад худалдаа, өнөөгийн байдал, “БелЭксимГарант” компанийн үйл ажиллагааны талаар санал солилцож, Монгол Улсад Экспортын даатгалын агентлаг байгуулахад мэдээлэл солилцож хамтран ажиллахаар болов.

Хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд худалдааны даатгалын талаар туршлага судлах болон хамтын ажиллагааг өргөжүүлэх, Канад улсын Экспортыг дэмжих байгууллагын (EDC) тухай мэдээллийг цуглуулж, хамтран ажиллах хүсэлт илэрхийлсэн захиа үйлдэж, цахимаар илгээв.

Монгол Улс, БНКаЗУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион явагдсан “Монгол, Казахстаны бизнес уулзалт”-д маркетингийн менежер, эрсдэлийн шинжээч нар оролцсон.

Уулзалтад БНКаЗУ-ын эрчим хүч, хоол хүнс, газар тариалангийн машин механизм, тоног төхөөрөмж, барилга, эм, сав баглаа боодлын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 15 аж ахуйн нэгж оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан ба тус компанийн төлөөллүүд БНКаЗУ-ын элчин сайд, “Казах Инвест” хөрөнгө оруулалтын агентлагийн Экспортыг дэмжих газрын захирал Нурлан Кудиряев, “Казах Экспорт” экспортын даатгалын компанийн

төлөөлөлтэй уулзаж, компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцон, экспортын даатгалын бүтээгдэхүүний талаар туршлага судлан, цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр болов. Мөн тус улсын 34 компани Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2016 онд нийт 18 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэх “**Экспортыг дэмжих төсөл**”-ийн нээлтийн арга хэмжээг Сангийн яам, Дэлхийн банктай хамтран 2017 оны 3 дугаар сарын 24-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Сангийн яам, Төслийн захирлын өгсөн чиглэлийн дагуу Экспортыг дэмжих Төслийг хэрэгжүүлэх нэгж, төслийг хэрэгжүүлэгч байгууллага, хариуцсан ажилтнуудад зориулсан төслийн хэрэгжилтийн явцын талаар нэгдсэн мэдээллээр хангах, төслийн үйл ажиллагаанд мөрдөж буй санхүү, худалдан авалт, хяналт-шинжилгээний заавар, журмыг дэлгэрэнгүй танилцуулах арга хэмжээнд оролцов.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн цахим хуудсан дотор Экспортын даатгалын газрын цахим хуудсыг бүрэлдэхүүн хэсэг болгон нээх эх загварыг гаргаж, шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр боловсруулан, Экспортыг дэмжих төсөл хэрэгжүүлэх нэгжийн цахим хаягтай холбон байршуулав. /[www.agreinsurance.mn/eid.mn/](http://www.agreinsurance.mn/eid.mn/) Тухайлбал, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, мэргэжлийн холбоодтой хийсэн уулзалт, сургалт, семинарт оролцсон байдлын тухай, экспортын даатгалын талаар танилцуулга, гадаад улс орнуудын туршлага, холбогдох судалгаа, дата мэдээллүүдийг байршуулсан болно. Мөн Худалдаа ба экспортын санхүүжилтийн агентлаг /ТХФ/-ийн цахим хуудсан дахь экспортын даатгал, худалдааны санхүүжилттэй холбоотой мэдээ мэдээлэл, хэвлэмэл тайлан, цахим видео хичээлүүдийг судлан, хэрэгтэй мэдээллүүдийг орчуулан, экспортын даатгалын газрын цахим хуудсанд байршуулав.

## **ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО, САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **5.1. Компанийн сангийн хөрөнгийн удирдлага, зохицуулалт**

#### Хадгаламжийн гэрээний загвар

Хадгаламжийн гэрээний загварыг шинээр боловсруулан батлуулсан ба компанийн хөрөнгөнөөс хадгаламж байршуулах бүрд тус гэрээний загварыг ашиглан гэрээ байгуулан ажиллаж байна. Тус гэрээний загварт эдийн засаг, банк санхүүгийн салбарын өнөөгийн байдал, хүүгийн түвшин тогтворгүй байгаа энэ үед аливаа эрсдэлийг бууруулах үүднээс арилжааны банкнуудад тавигдах шаардлагыг өндөрсгөж, хадгаламжийн нөхцөл, арилжааны банкны үйл ажиллагаатай холбоотой гэрээний зөрчилд тооцох хариуцлагыг тодорхой зааж өгсөн.

#### Хамтын эрсдэлийн сангийн дотоод журам

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 91/110 дугаар бүхий хамтарсан тушаалаар батлагдсан “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ын 3.5-д “Хамтын эрсдэлийн сан нь хууль тогтоомжид нийцсэн, СЗХ-ноос зөвшөөрсөн дотоод журамтай байна” гэж заасан. Хамтын эрсдэлийн сангийн үйл ажиллагаанд оролцогч даатгагчдын хамтарсан хурал, давхар даатгагчийн Гүйцэтгэх захирал, ажлын алба болон аудиторын эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, тэдгээрийн тус сантай холбоотой хуралдах, шийдвэр гаргах харилцааг зохицуулах зорилготой тус журмын төслийг МИД-д оролцогч даатгалын компаниуд, Андеррайтингийн газар, Ерөнхий хуульчтай хамтран боловсруулж 2017 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн даатгагчдын хамтарсан хурлаар батлууллаа.

МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журмын төслийг дахин боловсруулах, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулахаар СЗХ-ны хариуцсан ажилтнуудтай холбогдон ажиллаж байна.

#### Хөрөнгө зохицуулах журам

Компанийн мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх, удирдах, байршуулах, захиран зарцуулах болон хэлцэл хийхэд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн оролцоо, эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зорилго бүхий журмыг Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, компанийн ерөнхий хуульчтай хамтран боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 02/06 дугаар тогтоолын хавсралтаар “Хөрөнгө зохицуулах журам” нэртэйгээр батлуулан гаргалаа.

Тус журмын 4.1-д заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 04/39 дугаар тушаалаар байнгын ажиллагаатай ажлын хэсэг байгуулагдан журмын хүрээнд ажиллаж байна.

#### **5.2. Хөрөнгө оруулалтын орлого**

Алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх ажлын хүрээнд Улсын төсөв дэх Сангийн сайдын багцад суусан 3.5 тэрбум төгрөгийг Төрийн сангаас 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдөр өөрийн харилцах дансандаа татан төвлөрүүлэв. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02/03 дугаар тогтоолын дагуу өнгөрсөн жилүүдийн хуримтлагдсан ашгаас үлдэгдэл 2.0 тэрбум төгрөгийг Алдагдлаас хамгаалах санд шилжүүлсэн. Ингэснээр Алдагдлаас хамгаалах сангийн 15.0 тэрбум төгрөгийг бүрэн бүрдүүллээ.

#### Хадгаламж

Банкнүүдтай байгуулсан хадгаламжийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, харилцах, хадгаламжийн хүү, өгөөжийн тооцооллыг сар бүр хийн компанийн нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэсэн. Хугацааны эцэст орж ирэх хадгаламжийн хүүг нягтлан бодох бүртгэлд авлага хэлбэрээр бүртгэж байна.

2017 онд компанийн мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршууллаа. Үүнд:

- Алдагдлаас хамгаалах сангийн эхний 5.0 тэрбум төгрөгийн хугацаа 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр дуусаж, Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 04/93 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанаар арилжааны 7 банканд хүүгийн саналын хуудас хүргүүлсэн ба 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ажлын хэсэг ирүүлсэн саналыг дүгнэж, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 2.25 тэрбум төгрөгийг жилийн 16.5 хувийн, Төрийн банканд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 16.4 хувийн, Капитал банканд 1.5 тэрбум төгрөгийг жилийн 16.6 хувийн хүүтэйгээр тус тус хадгаламж хэлбэрээр байршуулахаар саналаа удирдлагад гаргаж, Гүйцэтгэх захирлын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04/10 дугаар тушаалаар;
- Хөрөнгө оруулалтын өгөөж болох 250.0 сая төгрөгийг Капитрон банканд 1 жилийн хугацаатай 16,6 хувийн хүүтэйгээр;
- 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Алдагдлаас хамгаалах сангийн 2.5 тэрбум төгрөгийн хадгаламжийн хугацаа дууссан ба Ажлын хэсэг арилжааны 4 банкнаас санал авч хуралдсан. 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Капитал банканд 1.5 тэрбум төгрөгийг 16.6 хувийн хүүтэйгээр, Улаанбаатар хотын банканд 1.0 тэрбум төгрөгийг 16.1 хувийн хүүтэйгээр;
- Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 04/56 дугаар тушаалаар Капитрон банканд 2.0 тэрбум төгрөгийг жилийн 16.0 хувийн хүүтэйгээр 12 сарын



- хугацаатай хадгаламж, Хас банканд 1.7 тэрбум төгрөгийг жилийн 17.0 хувийн хүүтэйгээр 13 сараар хадгаламж хэлбэрээр;
- Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 04/71 дугаар тушаалаар Худалдаа хөгжлийн банканд 5.0 тэрбум төгрөгийг, Улаанбаатар хотын банканд 4.5 тэрбум төгрөгийг тус тус жилийн 15.2 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 26-ний өдрийн 04/100 дугаар тушаалаар Капитрон банкин дахь 300016953, 300016981 тоот мөнгөн хадгаламжуудыг үргэлжлүүлэн жилийн 16 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 04/102 дугаар тушаалаар Худалдаа хөгжлийн банканд 450.0 сая төгрөгийг жилийн 15.2 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 04/103 дугаар тушаалаар Улаанбаатар хотын банканд 1.7 тэрбум төгрөгийг жилийн 15.7 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр; Дунд түвшний нөөц сангийн Хас банк дахь хадгаламжийн хугацаа 2017 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр дууссан ба сангийн хуримтлалын тооцоог хийж, Хас банканд 2017 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр 154.4 сая төгрөг, 11 сарын хугацаатай 14.8 хувийн хүүтэйгээр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 04/115 тоот тушаалаар Хаан банканд 5 тэрбум төгрөгийг жилийн 15.5 хувийн хүүтэйгээр, Улаанбаатар хотын банканд 1.5 тэрбум төгрөгийг жилийн 15.5 хувийн хүүтэйгээр, нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 06-ний өдрийн 04/117 дугаар тушаалаар Худалдаа хөгжлийн банканд 7.6 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэйгээр нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр;
  - Гүйцэтгэх захирлын 2017 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн 04/123 дугаар тушаалаар Төрийн банканд 150.0 сая төгрөгийг нэг жилийн хугацаатай хүүгийн орлогыг сар бүр харилцах дансандаа авч байх нөхцөлөөр тус тус байршууллаа.

Банкнүүдтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хүүгийн орлогыг хугацаанд нь бүрдүүлсэн. 2017 оны жил эцсийн байдлаар нийт 8 банканд 37.9 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж байршиж, тайлант онд нийт **3,989,722,955.35 /гурван тэрбум есөн зуун наян есөн сая долоон зуун хорин хоёр мянга есөн зуун тавин таван төгрөг гучин таван мөнгө/** төгрөгийн **хадгаламжийн хүүгийн орлого** олсон байна.

Капитрон банкны 4 тэрбум төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг улирлаар авахаар гэрээнд заасан учраас 63.3 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Мөн 2017 оны МИД-ын дээд түвшний хураамжид 487.8 сая төгрөгийг Улсын төсвөөс 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдөр компанийн Төрийн банкин дахь харилцах дансанд шилжүүлж авлаа.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн тушаалаар МИД-ын эрсдэлийн дунд түвшний санд 2017 оны МИД-ын нийт хураамжийн 5 хувь болох 116,405,748.09 төгрөгийг, МИД-ын дээд түвшний санд 82,534,316.78 төгрөгийн хөрөнгийг тус тус нэмж нөөцөлсөн.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/108 дугаар тушаалаар НЭУБД-ын хураамжийн 15 хувиар буюу 6,949,154.89 /зургаан сая есөн зуун дөчин есөн мянга нэг зуун тавин дөрвөн төгрөг наян есөн мөнгө/ төгрөгөөр Тариалангийн даатгалын нөөц санг байгууллаа. Мөн энэ нөөц санг Төлөөлөн удирдах зөвлөлийн 02/09 дугаар тогтоолоор холбогдох сангийн хуримтлагдсан ашгаас 34,745,774.46 /гучин дөрвөн сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун далан дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгөөр нэмэгдүүллээ.

“Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.2-т заасны дагуу 1/3 хэсэг болох 5.0 тэрбум төгрөгийг дөрвөөс доошгүй буюу нэг банканд 1.25 тэрбум төгрөгөөс илүүгүй, 3.3-т заасны дагуу 2/3 хэсэг болох 10.0 тэрбум төгрөгийг нэг банканд 20 хувь хүртэл буюу 2.0 тэрбум төгрөгөөс илүүгүй, нийлүүлж тооцвол нэг банканд 3.25 тэрбум төгрөг хүртэлх хэмжээгээр байршуулах боломжтой юм. Хүснэгт 5-д “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нийт сангуудын хөрөнгийн байршил, хуваарилалтыг харуулав.

Хүснэгт 5. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хадгаламжид байршуулсан мөнгөн хөрөнгө:

№	Байршил	Хэмжээ	Хүү	Гэрээгээр эхэлсэн хугацаа	Гэрээгээр дуусах хугацаа
1	Худалдаа хөгжлийн банк	450,000,000.00	15.20%	8/17/2017	8/17/2018
2	Худалдаа хөгжлийн банк	5,000,000,000.00	15.20%	6/5/2017	6/5/2018
3	Худалдаа хөгжлийн банк	7,600,000,000.00	15.00%	11/6/2017	11/6/2018
4	Капитрон банк	2,000,000,000.00	16.00%	5/16/2017	5/16/2018
5	Капитрон банк	1,000,000,000.00	16.00%	5/31/2017	5/31/2018
6	Капитрон банк	1,000,000,000.00	16.00%	6/6/2017	6/6/2018
7	Хаан банк	5,000,000,000.00	15.50%	11/2/2017	11/2/2018
8	Төрийн банк	1,250,000,000.00	16.40%	1/20/2017	1/20/2018
9	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1,250,000,000.00	16.50%	1/24/2017	1/24/2018
10	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1,000,000,000.00	16.50%	1/25/2017	1/25/2018
11	Капитал банк	1,500,010,001.97	16.60%	1/24/2017	1/24/2018
12	Капитал банк	250,000,000.00	16.60%	1/25/2017	1/25/2018
13	Улаанбаатар хотын банк	1,700,000,000.00	15.70%	9/18/2017	9/18/2018
14	Улаанбаатар хотын банк	1,500,000,518.86	15.50%	11/16/2017	11/16/2018
15	Улаанбаатар хотын банк	4,500,000,000.00	15.20%	6/6/2017	6/6/2018
16	Улаанбаатар хотын банк	1,000,000,000.00	16.10%	3/24/2017	3/24/2018
17	Хас банк	1,700,000,000.00	17.00%	5/17/2017	6/17/2018
18	Хас банк /9 сар/	2,054,871.90	14.10%	8/27/2017	8/27/2018
19	Хас банк /11 сар/	154,416,855.24	14.80%	9/6/2017	8/6/2018
20	ЗГҮЦ/банк сонгох	2,462,700,510.00	14.67%	5/9/2017	5/8/2018
21	Төрийн банк	150,000,000.00	15.00%	11/10/2017	11/10/2018
	Нийт	<b>40,469,182,757.97</b>			

#### Харилцах

Улаанбаатар хотын банк, Хас банк, Төрийн банкны харилцах дансны тусгай нөхцөлт гэрээний дагуу өдөр бүрийн үлдэгдэлд жилийн 4.8-7.8 хувийн хүүгийн орлого авах гэрээ байгуулсан. 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт **50,391,668.19 /тавин сая гурван зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран найман төгрөг арван есөн мөнгө/** төгрөгийн харилцахын хүүгийн орлого олсон байна.

#### Засгийн газрын үнэт цаас

Хөрөнгө оруулалтын ажлын хэсгийн 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрээр Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгөнөөс Засгийн газрын үнэт

цаас авахаар арилжаа идэвхтэй эрхэлж буй 5 үнэт цаасны компани руу үйлчилгээний шимтгэлийн санал, компанийн мэдээллийг нь авах хүсэлт явуулсан ба санал ирүүлсэн 3 үнэт цаасны компаниас “Новел Инвестмент” ҮЦК хамгийн бага шимтгэл буюу 0.0139 хувийн шимтгэл авахаар санал ирүүлсэн тул Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 04/51 дугаар тушаалаар тус компаниар дамжуулан 2017 оны 5 дугаар сарын 09-ны өдөр 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Засгийн газрын үнэт цаас авах захиалга өгч жилийн хугацаатай 2,462,700,510 /хоёр тэрбум дөрвөн зуун жаран хоёр сая долоон зуун мянга таван зуун арван/ төгрөгийн нийт үнэ бүхий 14.67 хувийн хүүтэй 28,230 ширхэг үнэт цаасыг худалдан авсан.

2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр худалдан авсан 77,289 ширхэг Засгийн газрын үнэт цаасны хугацаа 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр дуусгавар болж, 2017 оны эхнээс тооцвол 311 хоногийн өгөөж болох 956,984,754.03 /есөн зуун тавин зургаан сая есөн зуун наян дөрвөн мянга долоон зуун тавин дөрвөн төгрөг гурван мөнгө/ төгрөгийг хүлээн авлаа.

Мөн 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хугацаа нь дууссан Засгийн газрын үнэт цаасны 150 хоногийн өгөөж нь 582,472,157.14 /таван зуун наян хоёр сая дөрвөн зуун далан хоёр мянга нэг зуун тавин долоон төгрөг арван дөрвөн мөнгө/ төгрөгөөр тооцогдож, нийт **Засгийн газрын үнэт цаасны өгөөжөөр** тайлант онд **1,774,047,513.18 /нэг тэрбум долоон зуун далан дөрвөн сая дөчин долоон мянга таван зуун арван гурван төгрөг арван найман мөнгө/** төгрөг бүртгэлээ.

**Засгийн газрын үнэт цаас, хадгаламж болон харилцахын нийт хүүгийн орлогоор** 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **5,814,162,136.72 /таван тэрбум найман зуун арван дөрвөн сая нэг зуун жаран хоёр мянга нэг зуун гучин зургаан төгрөг далан хоёр мөнгө/** төгрөгийг төвлөрүүлж компанийн хөрөнгө оруулалтын орлогын төлөвлөгөөг 0.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

### **5.3. Компани өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар зах зээлийн судалгаа**

Судалгааны ажлын хүрээнд зах зээлийн орчин өөрчлөгдөхөд хөрөнгө оруулалтын эрсдэлд орохоос сэргийлэх, эрсдэлийг үнэлэх аргуудыг судалж байна.

Сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгийг амжилттай удирдах арга замыг эрэлхийлж, нөөц сангийн удирдлагыг сайжруулах нарийвчилсан судалгаа хийхийг зорьж ажилласан. Нөөцийн сангийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн сонирхлыг татах, даатгалын салбарт хувийн хөрөнгө оруулагчдыг татаж болох талаар судалгаа хийгдэж байна.

Хөрөнгө оруулалтын хэлбэрүүд, тэдгээрийн эрсдэлийн хүчин зүйлүүдийг илрүүлэх, үнэлэх аргачлалыг судлах, мөн тоон үзүүлэлтээр илэрхийлэн тайлбарлах судалгааны ажил хийлээ. Хөрөнгийн үнэлгээний аргачлал болон эрсдэлийн үнэлгээний аргачлал дээр тулгуурлан Хөрөнгө оруулалтын эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэх боломжийг судлан, өндөр өгөөжийг эрсдэл багатайгаар олж авах зорилготой судалгаа юм.

### **5.4. МИД-ын болон газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцоолол, олголт**

#### **МИД-ын нөхөн төлбөр**

МИД-ын 2016 оны борлуулалтаас үүсэх нөхөн төлбөрийн дүнг Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 2017 оны хагас жилийн мал тооллогын статистик мэдээнд үндэслэн тооцоолж, тулган баталгаажуулсан. Хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн 2016 онд малаа даатгуулсан нийт 18,738 малчин өрхөөс Архангай, Баян-Өлгий, Булган,

Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 26 сумын 806 малчин өрхөд **79,608,784.28 /далан есөн сая зургаан зуун найман мянга долоон зуун наян дөрвөн төгрөг хорин найман мөнгө/** төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор тооцоолсон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/07 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/102 дугаар тушаалын дагуу бүрэн олгосон.

МИД-ын нийт нөхөн төлбөр болох 79.6 сая төгрөгийн 78.4 сая төгрөгийг ХЭС /Хамтын эрсдэлийн сан/-гаас, 1.2 сая төгрөгийг дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас тооцож олголоо.

#### Нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгалын нөхөн төлбөр

НЭУБД-д хамрагдсан 9 аж ахуйн нэгжийн даатгуулсан талбайд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Ард даатгал” ХХК-ийн төлөөлөл бүхий хохирол үнэлгээний баг урьдчилсан болон бодит ургац тогтоолтын ажил хийсэн. Ургац тогтоолтын үр дүнд 4 аж ахуйн нэгжид нийт **211,173,419 /хоёр зуун арван нэгэн сая нэг зуун далан гурван мянга дөрвөн зуун арван есөн/** төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тооцоологдож, Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/116 дугаар тушаалын дагуу нөхөн төлбөрийг бүрэн олгосон.

Энэхүү нөхөн төлбөрийг гэрээний дагуу “Ард даатгал” ХХК 3 хувь буюу 6,335,202.58 /зургаан сая гурван зуун гучин таван мянга хоёр зуун хоёр төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийг, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК 17 хувь буюу 35,899,481.30 /гучин таван сая найман зуун ерэн есөн мянга дөрвөн зуун наян нэгэн мянган төгрөг гучин мөнгө/ төгрөгийг, СКОР /“SCOR”/ олон улсын давхар даатгагч 80 хувь буюу 168,938,735.52 /нэг зуун жаран найман сая есөн зуун гучин найман мянга долоон зуун гучин таван төгрөг тавин хоёр мөнгө/ төгрөгийг тус тус хувь тэнцүүлэн олголоо.

## **ЗУРГАА. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **6.1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал**

Компанийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн нэг жилийн хугацаатайгаар байгууллаа. Ялгавартай байсан цалингийн хэмжээг ажил үүргийн онцлогоос хамааруулан тэгшитгэн тогтоох зарчим баримтлан зөрүүг нь ойртуулан шинэчлэн тогтоолоо.

Ажлын байрны тодорхойлолтод 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудтай нийцүүлэн нэмэлт өөрчлөлт хийж газрын дарга, ерөнхий хуульч нараар шат дараатай хянуулан Гүйцэтгэх захирлаар батлууллаа.

Ажилтнуудын 2016 оны хөдөлмөрийн гэрээний биелэлтийг газрын дарга нар дүгнэж үнэлгээ өгсөн. Мөн компанийн ажилтнуудын 2017 оны хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, үр дүнгээр нь “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу урамшуулал олгосон. Мөн хариуцсан ажилдаа амжилт гаргасан 1 ажилтан Төрийн шагналаар, 10 ажилтан Монгол Улсын Засгийн газрын шагналаар, 3 ажилтан Монголын Залуучуудын Холбооны шагналаар тус тус шагнагдлаа.

Компанийн 2017 оны “Олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан мөрдөн ажиллаж байгаа ба төлөвлөгөөнд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 7 ажил тусгагдсан байна.

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Чингис хаан” дээд сургуулийн спорт заалтай 02 дугаар сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний дагуу 7 хоног бүрийн 3 дахь өдөр 18:00-20:00 цагийн хооронд спортоор хичээллэсэн. Мөн “Голден жим” фитнес клубтэй гэрээгээ сунган хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн төлөвлөгөөний дагуу 02 дугаар

сарын 18-ны өдөр цасны баярыг зохион байгууллаа. Ажилтнууд идэвхтэй оролцож цана болон сноубордоор гулган нэг өдрийг цэвэр агаарт идэвхтэй өнгөрүүллээ.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар хэд хэдэн эмнэлгийн үнийн санал багцын шинжилгээг судаллаа. Багцын шинжилгээг харьцуулан үзэж нийт ажилтнуудаас санал аван нэгтгэн удирдлагуудад танилцуулсны эцэст Грандмед эмнэлгийн багцыг сонгон үйлчлүүлэхээр болсон юм. Нийт ажилтнуудыг 3 ээлжид оруулан 9 дүгээр сарын 22-ны өдрөөс 26-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу шинээр бүл нэмж хүүхэдтэй болсон 5 ажилтан, гадаад улсад эмчлүүлэхээр явсан 3 ажилтан, шинээр гэр бүл болсон 1 ажилтан, ар гэрт нь гачигдал тохиолдсон 2 ажилтан нийт 11 ажилтанд 17.64 сая төгрөгийн буцалтгүй тусламж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан 1 ажилтанд 0.6 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлэв.

Байгууллага хамт олны Улан-Үд-Итгэлт хамбын аяллыг 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Татварын ерөнхий газраас 2017 оны 11 дүгээр сард Сангийн яамны харьяа байгууллагуудын дунд зохион байгуулсан спортын арга хэмжээнд идэвхтэй оролцож, эрэгтэй, эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд багаараа хүрэл медаль авч, багийн дүнгээр 4 дүгээр байранд орсон амжилт үзүүлсэн.

Мөн Монголын даатгагчдын холбооны Спортын их наадам 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 19-ний өдрүүдэд спортын 5 төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд энэхүү уралдаан тэмцээнүүдэд баг хамт олноороо амжилттай оролцлоо.

## **6.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт**

Компанийн 2017 оны санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөг газар нэгж тус бүрээс орлого, зарлагын төлөвлөгөөг нарийвчлан гаргуулж, нэгтгэн гүйцэтгэх удирдлагаар хянуулан бэлэн болгосон ба компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02/02 дугаар тогтоолоор батлуулж, Гүйцэтгэх захирлын баталсан төсвийн хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явууллаа.

2017 оны санхүүгийн төлөвлөгөөг 2016 оныхтой харьцуулахад нийт зардлын хэмжээг 14.4 хувиар бууруулж төлөвлөсөн бөгөөд **2017 оны төсвийн гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 115 хувиар** биелсэн ба **бараа үйлчилгээний нийт зардал 9.4 хувийн хэмнэлттэй** гарсан байна.

2017 оны батлагдсан төсөв дээр дүн шинжилгээ хийж, газар тус бүрээс ирсэн төсвийн саналуудыг нэгтгэн 2018 оны төсвийг бодитойгоор зардал тус бүрээр нь боловсруулан удирдлагаар хянуулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахад бэлэн болголоо. 2018 оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулахдаа загварыг өөрчлөн ашигт ажиллагааг бодитойгоор тооцож болохоор оруулсан.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн хооронд 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах ажилд зөвлөгөө өгч, хамтран ажиллалаа. Тус компанийн боловсруулан бэлтгэж буй баримт бичигт өөрсдийн боловсруулсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Дансны жагсаалтыг гарган өгч орууллаа. Мөн компанид шаардлагатай байгаа “Бизнесийн нэгдэл” гэсэн бүлгийг шинээр санал болгон оруулсан. Ийнхүү ажилласны үр дүнд 2017 оны 9 дугаар сарын 27-ны өдөр баримт бичгийг хүлээн авлаа.



2017 оны 3 дугаар улиралд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн санхүү бүртгэл хөтлөлт, тайлан бэлтгэх үйл явцыг Сангийн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2015 оны 11 сарын 09 өдрийн 306/307 дугаар тушаалын дагуу Даатгалын компанид мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дансны жагсаалт
- Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга
- Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал”

Сангийн яам, СЗХ, татварын хэлтэст 2016 оны жилийн эцсийн тайланг цаасаар болон цахимаар хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мөн хуулийн хугацаанд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг холбогдох газруудад хүргүүлсэн.

Санхүүгийн 2017 оны эхний 3 улирлын тайланг хугацаанд нь бэлтгэн зохих газруудад хүргүүлсэн бөгөөд тайлангийн хариугаар санхүү, бүртгэл, тайлагналын талаар алдаа гараагүй болно. Мөн нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 10-ны дотор гарган холбогдох байгууллагад хүргүүлж байна. Ажилтан тус бүрийн нийгмийн даатгалын дэвтэр дээр бичилт хийж, баталгаажуулж байна.

СЗХ-ноос ирүүлсэн нөөц сангийн журам болон бусад хууль тогтоомжийн шинэчилсэн төсөлтэй танилцаж саналаа хүргүүлсэн. Үүнд: Давхар даатгалын компанийн нөөц сангийн журмыг шинээр боловсруулан батлах, хамтарсан ажлын хэсэг гарган ажиллах, одоо мөрдөгдөж байгаа 3 нөөц сангийн журам, “Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн журам”-ыг шинээр боловсруулах зэрэг болно.

Нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохистой явуулахын тулд Санхүүгийн “Unicus” програмын шинэ хувилбарыг сонгон авч, 2017 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн бүх гүйлгээг хөрвүүлэн шинэчлэн шивсэн. Энэ хугацаанд эхний хагас жилийн явцад хийгдсэн зарим санхүүгийн гүйлгээнүүдийн алдаануудыг засаж залруулсан болно. Тус програм дээр төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүрээр бэлтгэн гаргах модулийн загварыг шинээр боловсруулсан бөгөөд 2018 оны 1 дүгээр сараас эхлэн ажиллуулахад бэлэн болгож бэлтгэсэн.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ААНОАТ-н төлөлтийн талаар Сүхбаатар дүүрэг болон Нийслэлийн татварын албатай удаа дараа уулзалт зохион байгуулсны үндсэн дээр /2016 оны хагас жилээр Сүхбаатар дүүргээс Нийслэлийн татварын алба руу шилжсэнээр өр, авлага үүсэж харилцан ойлголцохгүй байсан/ авлага, өглөгөө амжилттай тулган баталгаажууллаа. Мөн Сүхбаатар дүүргийн татварын албан дээр ХХОАТ суутган-1, ХХОАТ суутгагчаас суутгасан татварын өглөгийг тулган баталгаажуулж өөрсдийн бүртгэлтэйгээ тааруулсан.

Компанийн улирлын тайланг хураангуй байдлаар бэлтгэн компанийн цахим хуудсанд байршуулж байна.

Ажилтнуудын ирц, цагийн бүртгэлийг сар бүрийн 19-ний өдрөөр тасалбар болгон цаг бүртгэлийн машинаар баталгаажуулан, Гүйцэтгэх удирдлага болон дотоод хяналтын ажилтанд танилцуулж, цалинг тооцон олгож байна. Ингэхдээ “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу тасалсан, хоцорсон цагийн цалинг тооцон суутгал хийж байна. 2017 онд цагийн бүртгэлийн тооцоогоор 12 ажилтанд 3 сар хүртэл хугацаагаар сарын цалинг нь 20 хувь хүртэл бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан.

Сар бүр ажилтнуудад цалингийн мэдээллийг хүргүүлж байна. Амралтаа авч байгаа ажилтнуудад амралтын тооцооны хуудас бөглүүлэн захирлын зөвшөөрлийн дагуу амралтын мөнгө тооцож олгов.

Гадаад болон дотоод томилолтын албан томилолтын хуудсыг бөглөж, байгууллагын тамга, Санхүү удирдлагын газрын даргын зөвшөөрлийн гарын үсэг зуруулж, томилолтоор явж байгаа ажилтанд томилолтын тооцооны удирдамжтай хамт хүлээлгэн өгч байна. Томилолтын бүртгэлийг газар нэгж бүрээр нь хөтөлж, тайлан, гүйцэтгэлийг нягтлан шалгаж хүлээн авч байна.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 04/35 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр”-ийн дагуу сар бүр Монгол Банкны санхүүгийн албанд холбогдох тайланг хүргүүлж байна.

Компанийн мөнгөн хөрөнгийг данс бүрээр нь банкнаас харилцагч арилжааны банкнуудаас баталгаажуулалт гаргуулан авч СЗХ-нд хүргүүлсэн. 2016 оны санхүүгийн тайлан /аудитаар баталгаажуулсан/ СЗХ-ны FINA санхүүгийн програмтай зөрүүтэй байсныг илрүүлэн залруулаа.

Анхан шатны баримтын бүрдлийг тухай бүрд нь цэгцлэн, дотоод хяналтын ажилтнаар хянуулан ажиллаж байна. Харилцагч банкнуудаас мөнгөн хөрөнгө, хадгаламжийн үлдэгдлийн баталгааг хагас бүтэн жилээр хүлээн авсан.

Бэлэн мөнгө хүссэн өргөдлийн дагуу Гүйцэтгэх захирлын зөвшөөрснөөр Санхүү, удирдлагын газрын даргад танилцуулан бүртгүүлсний дараа бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийгдэж байна. Мөн сар бүрийн жижиг мөнгөн сангийн тайлан гаргаж, Санхүү, удирдлагын газрын даргад танилцуулж байна.

Сар бүрийн эцэст төсвийн гүйцэтгэлийн мэдээг шууд санхүүгээс гарган Гүйцэтгэх захирал, Санхүү, удирдлагын газрын дарга, дотоод хяналтын ажилтан нарт тогтмол мэдээлэл өгч ямар зардал дээр анхаарах, хөрөнгө оруулалт хэрхэн байршуулах тал дээр санал боловсруулан ажиллаж байна.

### **6.3. Худалдан авах үйл ажиллагаа**

Компанийн 2016 оны худалдан авах үйл ажиллагааны баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалтыг хариуцан, хуулийн дагуу бүрдүүлэн хадгалж хөндлөнгийн аудитын шалгалтаар оруулав.

Тус компанийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 12 төрлийн арга хэмжээ тусгагдсанаас “Оффисын байрны түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах”, “Аудитын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах”, “Цаг тооны бичиг хэвлүүлэх” зэрэг 3 худалдан авалтын тендер шалгаруулалтыг зарлан хэрэгжүүлсэн. “Өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварын үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт явагдаагүй, бусад 8 худалдан авалтыг шууд худалдан авах замаар амжилттай зохион байгуулсан. Эдгээр худалдан авах арга хэмжээний төсөв нь 341.5 сая төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэл нь 104.8 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Худалдан авах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 91.7 хувьтай байна.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу оффисын байрны түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зарласан. Тендерийн нээлтийг 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хийж, үнэлгээ хийсэн ба шаардлага хангасан тендер ирүүлсэн “Булнайн Ар” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулсан.

Компанийн сурталчилгааны Цаг тооны бичгийг хэвлүүлэх тендер шалгаруулалтыг Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/02 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг харьцуулалтын аргаар зохион байгуулсан. Худалдан авалтыг 2017 оны 01 дүгээр сарын 05-

ны өдөр зарласан бөгөөд 01 дүгээр сарын 13-ны өдөр нээж үнэлсэн. “Шинэ өнгө” ХХК, “Эх дардас” ХХК, “Тод үсэг” ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж үнийн саналаа ирүүлснээс техникийн тодорхойлолтын шаардлага хангасан, хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Шинэ өнгө” ХХК-ийг шалгаруулж, 20.0 мянган ширхэг цаг тооны бичгийг хэвлүүлэх гэрээ байгуулан хэрэгжүүллээ.

Компанийн 2017 оны худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу компанийн 2016 оны санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/15 дугаар тушаалаар байгуулсан Үнэлгээний хороо зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зарласан ба 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр нээж үнэлгээ хийх байсан боловч нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул хойшлуулсан.

Ажлын байрны хэрэглээний зүйлсийн худалдан авалтыг захиргааны ажилтан хариуцаж, баримт бичгийг бүрдүүлэлтийг бүрэн хийж, кассын дэвтрийн бүртгэлийг хөтлөн цаг тухай бүрд нягтлан бодогчтой тооцоо нийлэн ажиллаж байна.

#### **6.4. Компанийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаа**

Газар нэгжийн ажлын төлөвлөгөөг сар, улирлын хуваарьтайгаар гаргуулан “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасан хугацаанд нь батлууллаа. Компанийн бизнес төлөвлөгөө, газар нэгжийн санал, хөндлөнгийн байгууллагуудын хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмж, аудитын байгууллагын зөвлөмжүүд дээр үндэслэн компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хянуулж, Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/14 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажилласан.

Ажилтан бүрийн улирал тутам хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан газар нэгжээр нэгтгэн, газрын дарга нараар хянуулан баталгаажуулав.

Газар нэгжийн ирүүлсэн улирал бүрийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг нэгтгэн компанийн улирал бүрийн ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг гаргасан. Тус компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 92.7 хувиар биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

Албан бичгийн төслийг удирдлагууд хянаж, гарын үсэг зурсны дараа албан хэвлэлийн хуудсан дээр бичиг хэргийн шаардлага, стандартын дагуу хэвлэн гаргаж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн ажиллаж байна. 2017 онд 133 Гүйцэтгэх захирлын тушаал, 266 албан бичгийг боловсруулсан гаргасан ба гаднаас ирсэн 139 албан бичгийг бүртгэн удирдлагын цохолтын дагуу холбогдох албан тушаалтнуудаар хариу, биелэлтийг нь гаргуулан хүргүүлсэн.

2016 оны Гүйцэтгэх захирлын тушаал, ирсэн албан бичиг, гарсан албан бичиг болон санхүүгийн баримтуудыг цэгцлэн бүртгэж, 26 архивын нэгж болгон архивлав.

Ажилтнуудын цаг ашиглалтын талаар мэдээлэл хийж цахим хаягаар дамжуулан нийтэд нь анхааруулга, оффисын зориулалтын хувцас өмсөж хэвших талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Компанийн албаны хэрэглээнд ашиглагдаж байгаа авто машинуудыг тээврийн хэрэгслийн даатгалд, жолооч нарыг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд тус тус бүрэн хамруулсан. Авто машинуудын моторын тос солих, бусад тосолгоо, шаардлагатай засвар үйлчилгээг цаг хугацаанд нь бүрэн хийж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Ажилтнуудын компьютер, байгууллагын дотоод файлын сервер болон вэб сервер, өгөгдлийн сангийн серверийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. Програмын болон баталгаанаас гарсан алдаа зөрчлийг цаг тухай бүрд нь засаж залруулан ажиллаж байна.

Ажлын байрны эмх цэгц, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, зарцуулалт, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг туслах нягтлан бодогч, захиргаа, худалдан авалт хариуцсан ажилтан нар хариуцан ажиллаж байна. Агуулахын эмх цэгцийг сайжруулан ажил үүргийн хуваарийн дагуу туслах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.

МИД төслөөс шилжин ирсэн хөрөнгийг эд хөрөнгийн балансад тусгалаа. Байгууллагын эд хөрөнгийг ажилтан тус бүр дээр хөрөнгийн карт нээж, бүртгэлд тусган авсан. Агуулах дахь бараа материал, хөрөнгийн жагсаалт гаргаж бүртгэл хөтөлж, дансны дарааллаар байршуулан хадгалж байна.

Үндсэн хөрөнгийн тооллогыг Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 04/110 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хийв. Тооллогоор эд хөрөнгийг шинээр кодлуулан эзэмшигч бүрээр картлан, бүртгэлгүй байсан эд хөрөнгийг бүртгэсэн ба ашиглах боломжгүй болсон хөрөнгийн жагсаалтын гарган актлах, данснаас хасах комиссын дүгнэлт гарсан. Үүний дагуу Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/118 дугаар тушаалаар үлдэх өртөг бүхий 28 нэр төрлийн, үлдэх өртөггүй 64 нэр төрлийн эд хөрөнгийг акталж, данснаас хасалт хийлээ.

“Unicus” санхүүгийн програмд үндсэн хөрөнгийн бүртгэлийг шинээр бий болгон бүртгэлийг ангилал тус бүрээр нь ашигласан хугацаа, элэгдэл, үлдэх өртөг зэргээр үндсэн хөрөнгийн бүртгэл хийсэн. Мөнгөн хөрөнгө, бараа, түүхий эд материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, эд хогшил болон тэдгээрийн хүлээн авалт, хадгалалт, зарцуулалтыг хариуцаж ажиллаж байна. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт зарцуулалт хөдөлгөөн өөрчлөлтийг журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын томилолтын тооцоог гаргах, визний үйлчилгээнд хамрагдах болон бусад бэлтгэл ажлыг цаг тухай бүрд нь ханган ажилласан.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газраас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг хүргүүлсэн.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/52 дугаар тушаалаар компанийн Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс, 04/54 дүгээр тушаалаар компанийн Хөдөлмөрийн маргаан таслах комиссыг тус тус байгуулан ажиллаж байна.

Мөн Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/53 дугаар тушаалаар компанийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журмыг баталж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг байгуулсан.

Шуурхай хуралдааны биелэлтийг холбогдох албан тушаалтнуудаас тодруулан гаргуулан авч, биелэлтийг нь дүгнэн ажиллаж байна.

#### **6.5. Хуулийн хэрэгжилт, дотоод хяналт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажил**

Компанийн 2017 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний дагуу 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан дотоод сургалтын хүрээнд “Авлига гаргах боломжийг хэрхэн бууруулах тухай” сургалтыг явууллаа.

2016 оны тайлант хугацаанд нийт 13 хүн мэдүүлэг гаргахаар бүртгэлтэй байсан боловч Гүйцэтгэх захирлыг Сангийн яаманд мэдүүлэг өгөхөөр шилжүүлэн татаж, тайлант хугацааны 8 мэдүүлэг гаргагч, шинээр томилогдсон 4 мэдүүлэг гаргагч мэдүүлэв. Мэдүүлэг гаргагч нар хуулийн хугацаанд мэдүүлгийг бүрэн гаргаж тайлагнасан.

Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл, МИД-ын зуучлагч 2 банктай хамтран ажиллах гэрээ болон зуучлалын гэрээний загвар, оролцогч даатгалын компаниудтай МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээний загвар, банкнуудтай байгуулах хадгаламжийн гэрээний загвар болон бусад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулах гэрээний загвар, дотоод үйл ажиллагааны дүрэм, журмын төсөл зэргийг хууль эрх зүйн хүрээнд хянан боловсруулж батлуулсан. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал, гадагшаа явуулж байгаа албан бичгийн төслийг хянах, засварлах зэргээр компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг ханган ажиллалаа.

Даатгалын зохицуулалтын журмуудыг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан “Сайн дурын даатгалын хэлбэрийн шинэчлэн батлах тухай журам”, “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-уудад санал боловсруулж, СЗХ-нд хүргүүлсэн.

СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газраас тус компанийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх, илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилтийн явцын тайланг 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 03/102 тоот албан бичгээр СЗХ-нд хүргүүлээ. Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллав.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 04/67 дугаар тушаалаар компанийн 2015, 2016, 2017 оны санхүүгийн баримтын бүрдүүлэлт, аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцах, ажилтнуудын цалин, амралтын тооцоог нягтлах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан батлагдсан удирдамжийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 6 дугаар сарын 02-ны өдрүүдэд ажиллалаа. Энэ хугацаанд илэрсэн зөрчлүүдийг арилгуулж ажилласан бөгөөд дотоод хяналтын ажилтны зүгээс зөвлөмж ирүүлсэн. Шалгалтаар компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчиж байгууллагын итгэлийг алдсан нягтлан бодогчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөв.

Компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр буюу Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар компанийн дүрмийг баталж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хороодод томилох тухай, компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөг батлах тухай, хуримтлагдсан ашгаас Алдагдлаас хамгаалах санд шилжүүлэх тухай, МИД-ын 2017 оны борлуулалтын улиралд ашиглах гэрээний загвар, малын үнэлгээг батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай, компанийн Хөрөнгө зохицуулах журам батлах тухай, 9 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар Нөхөн төлбөр олгох тухай, 9 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар Давхар даатгалын гэрээ байгуулах тухай, Нөөц сангийн хөрөнгийг хуримтлагдсан ашгаас нэмэгдүүлэх тухай тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.



-----oOo-----

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК  
14210, Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайваны өргөн чөлөө-23,  
“UBH center”, 14 давхар, 1412 тоот  
Э-шуудан: [info@agreinsurance.mn](mailto:info@agreinsurance.mn)  
Вэб: [www.agreinsurance.mn](http://www.agreinsurance.mn)  
Утас: 75770002  
Факс: 75770003